



Хөгжил дэвшлийг  
хамтдаа бүтээе



# ОЮУ ТОЛГОЙ ҮЙЛДВЭР

ЖИЛИЙН ТАЙЛАН 2025



Хөгжил дэвшлийг  
хамтдаа бүтээе



ЖИЛИЙН ТАЙЛАН  
2025



## МАНАЙ БИЗНЕС

*Оюу толгой үйлдвэр бол хамтын ажиллагаа, түншлэлээр тэтгэгдэж бүтсэн амжилтын түүх юм.*

*Дэлхийн энтэй энэхүү зэс, алтны уурхай нь Монгол Улсын Өмнөговь аймагт, Улаанбаатар хотоос өмнө зүгт 550 км, Монгол-Хятадын хилээс хойш 80 км орчимд байрладаг. Оюу толгой үйлдвэр нь дэлхийд одоогоор илрүүлсэн өндөр агуулгатай зэсийн хамгийн том ордын нэг бөгөөд Монголын хамгийн том, хамгийн дэвшилтэт үйлдвэрлэлийн цогцолбор болж хөгжлөө.*

*“Оюу толгой” ХХК нь “Рио Тинто” компани (66%) болон “Эрдэнэс Оюу толгой” ХХК (34%)-ийн стратегийн түншлэл бол “Эрдэнэс Оюу толгой” нь Монгол Улсын төрийн өмчит аж ахуйн нэгж юм. 2010 оноос хойш “Рио Тинто” компани стратеги, үйл ажиллагааны менежментийн үйлчилгээг Оюу толгой үйлдвэрт үзүүлж, аюулгүй ажиллагаа, технологи, тогтвортой хөгжлийн дэлхийн түвшний стандартыг хэрэгжүүлж байна.*

## Ирээдүйн төсөөллийн мэдэгдэл

Тус тайланд урьдчилан таамагласан ирээдүйн тооцоолол болон мэдээлэл багтсан болно. Иймд тус үйл ажиллагааны төсөөлөл, тооцоолол, мэдээлэл нь ирээдүйн үйл явдал эсхүл ирээдүйн гүйцэтгэлээс хамаарах бөгөөд Оюу толгой үйлдвэрийн одоогийн төлөвлөгөө, төсөөлөл, тооцоололд тулгуурласан болно. Иймд ирээдүйд учирч болох ямар нэг хүчин зүйлээс хамааран төлөвлөлт, тооцоололд өөрчлөлт орж, бодит байдалтай нийцэхгүй байх эрсдэлтэйг анхаарна уу. Иймээс аливаа ирээдүйн тооцоолол, төлөвлөгөөнд баталгаа өгөхгүй болохыг анхаарна уу.

Эдүгээ бид дэвшилтэд технологи бүхий ил уурхай, дэлхийн түвшний гүний уурхайг ашиглалтад оруулж, дэвшилтэт аюулгүй ажиллагааны систем, сүүлийн үеийн технологийг ашиглан олборлолт явуулж байна. Орчин үеийн баяжуулах үйлдвэр болон дагалдах дэд бүтэц нь нарийн төвөгтэй үйл ажиллагааг өндөр нарийвчлал, сахилга баттай удирдах боломжийг бий болгодог билээ.

Монголын хамгийн том гадаадын шууд хөрөнгө оруулалт бөгөөд улс орны эдийн засгийн нэгэн тулгуур болохын хувьд Оюу толгой үйлдвэрийн амжилт нь Монгол Улсын ирээдүйн хөгжил дэвшилтэй салшгүй холбоотой юм. Бид урт хугацааны “Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе” стратеги дор тогтвортой өсөлтийг хадгалж, орон нутаг, цаашлаад Монгол Улсад үнэ цэнэ тогтмол бий болгон ажиллаж байна. Гүний уурхайн олборлолт тасралтгүй өсөж, шинэ технологийн үр ашиг нэмэгдэхийн хэрээр Оюу толгой үйлдвэр дэлхийд зэсийн үйлдвэрлэлээр эхний дөрөвт багтах зорилгодоо ойртож, хүлэмжийн хийг бууруулах дэлхийн нийтийн үйлсэд ч чухал үүрэг гүйцэтгэх юм.





# ХӨГЖИЛ ӨӨД ХАМТ ТЭМҮҮЛСЭН 16 ЖИЛ

Оюу толгой үйлдвэрийн бүтээн байгуулалт бол Монголын түүхэнд хийгдсэн хамгийн том бөгөөд тууштай үргэлжилж буй гадаадын хөрөнгө оруулалтын үр дүн юм. Энэхүү урт хугацааны хөрөнгө оруулалтаар дэлхийд танигдсан уул уурхайн мэдлэг туршлага, дэвшилтэт технологи, олон улсын үйл ажиллагааны стандартыг нутагшуулж, улмаар олон улсад хуруу дарам цөөнд тооцогдох өндөр төвөгшилтэй гүний уурхайг амжилттай цогцлоох нөхцөлийг бүрдүүлсэн юм.

2010 оноос ил уурхай ашиглалтад орж, 2023 онд гүний уурхайн үйлдвэрлэл эхэлснээр дэлхийн хамгийн сүүлийн үеийн зэсийн цогц уурхайн нэг Оюу толгойд цогцлов. Өнгөрсөн арван зургаан жилийн хугацаанд “Оюу толгой” ХХК нь дотоодод ажлын байр шинээр бий болгох, дэд бүтцийг хөгжүүлэх, улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэх үйл хэрэгт ил тод байдал, түншлэл, хамтын ажиллагаагаар манлайлан хувь нэмрээ оруулж ирлээ.

Олон улсын хөрөнгө оруулагчид олон тэрбум ам.долларын бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх, тэр дундаа дэлхийд техникийн шийдлийн хувьд хамгийн нарийн төвөгтэйд тооцогдох гүний уурхайг босгоход чухал хувь нэмэр оруулж байна. Энэ хөрөнгө оруулалт нь тогтвортой засаглал, ил тод байдал, олон улсын тогтвортой хөгжлийн стандартуудыг чанд мөрдөж ордын нөөцийг хариуцлагатайгаар ашиглах үндсийг тавьсан билээ. Ийнхүү хөрөнгө оруулалтын мөнгөн урсгал, техникийн өндөр чадавх, үйл ажиллагааны сахилга батын тусламжтайгаар сорилт бэрхшээл, хувьсан өөрчлөгдөж буй нөхцөл байдлыг даван туулж ирлээ.

Үр дүнд нь Оюу толгой гадаадын хөрөнгө оруулалтын жишиг түншлэл болов. Энэхүү алсын хараатай урт хугацааны хөрөнгө оруулалт нь алслагдсан бүс нутагт дэлхийд данстай уурхайн цогцолборыг бүтээж, хөгжил дэвшилд хөтөлсөн өөрчлөлтийг авч ирэв. Цаашдын тогтвортой хамтын ажиллагаа нь үйлдвэрлэлийн бүтээмжийг өндөрт хадгалан, эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжиж, Монгол Улсыг дэлхийн тавцанд зэсийн нийлүүлэлтээр чухал тоглогч болгох бат бөх суурийг тавьж чадлаа.

# ЦЭВЭР БӨГӨӨД ТОГТВОРТОЙ ИРЭЭДҮЙГ ОЮУ ТОЛГОЙ ҮЙЛДВЭР ХЭРХЭН ДЭМЖДЭГ ВЭ?

Эрчим хүчний шилжилт хурдсахын хэрээр Оюу толгой үйлдвэр нь олон улсын туршлага, дотоодын чадварлаг ажиллах хүчний давуу талаа ашиглан олон улсын тавцанд зэсийн гол нийлүүлэгчдийн нэг болж байна. Зэс нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, зай хураагуур, цахилгаан дамжуулах сүлжээ, цахилгаан тээврийн хэрэгсэл үйлдвэрлэлд шаардлагатай үндсэн түүхий эд. Ийм ч учраас Олон улсын эрчим хүчний агентлаг хийгээд бусад судалгааны хүрээлэнгийн судалгаануудад 2030–2050 онд байгаль орчинд ээлтэй технологи нэвтрэхийн хэрээр зэсийн эрэлт эрчимтэй өснө гэж таамаглажээ. Дэлхийн хамгийн томд тооцогдох зэс үйлдвэрлэгчдийн нэг болох Оюу толгой үйлдвэр хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад зайлшгүй шаардлагатай энэхүү түүхий эдийг бүрэн хүчин чадлаараа үйлдвэрлэж эхлэх үед жилдээ зургаан сая давсан цахилгаан автомашинд шаардагдах хэмжээний зэс үйлдвэрлэнэ. Нийлүүлэлтээс давсан эрэлт үүсэх хүлээлттэй байгаа энэ үед Оюу толгой үйлдвэрийн тогтвортой зэсийн нийлүүлэлт нь цахилгаан түгээх сүлжээний хүчин чадал, цахилгаан үүсгүүрт тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлж байгальд илүү ээлтэй бөгөөд хүлэмжийн хийн ялгарал бага ирээдүйг цогцлооход хувь нэмэр оруулж байна.

Оюу толгой үйлдвэрийн ирээдүйн өсөлт хөгжил нь Монгол Улсыг дэлхийн зэсийн салбарын гол тоглогчдын нэг болгоод зогсохгүй улс орны хөгжил цэцэглэл, дэлхийн эрчим хүчний шилжилтэд урт хугацааны өгөөжөө өгсөөр байх болно.


## ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТЭЭС ҮҮДСЭН ЗЭСИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ӨСӨЛТ ХИЙГЭЭД НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХОМСДОЛ

Цахилгаанжуулалт, сэргээгдэх эрчим хүч болон цахилгаан үүсвэрт автомашины үйлдвэрлэл эрчимжиж буйн нөлөөгөөр олон улс дахь зэсийн эрэлт нийлүүлэлтийн бүтэц өөрчлөгдөж байна. Улмаар зэсийн шинэ орд нээгдэж нийлүүлэлт өсөөгүй нөхцөлд 2030-аад оны дунд үе гэхэд хомсдол нэг сая тоннд хүрэхээр байна.

# Хүдрээс металл хүртэл

Оюу толгойн уурхай 3.4 тонн чулуулгаас  
29 кг зэс гарган авдаг.

Үүгээр нэг цахилгаан автомашин  
үйлдвэрлэдгийг та мэдэх үү?



**31%**

Тоног  
төхөөрөмж



**28%**

Барилга  
байгууламж

Дэлхийн  
зэсийн  
хэрэглээ,  
салбараар

Ашиглалт  
нэмэгдсэнээр  
хэрэглээ  
өөрчлөгдөж  
байна.



**16%**

Дэд бүтэц

**12%**



Аж үйлдвэр

**13%**



Зам  
тээвэр

# Хөрөнгө оруулалт, зэс үйлдвэрлэл, мөнгөний урсгал

Оюу толгойн бүтээн байгуулалтын үр дүнд их хэмжээний гадаадын хөрөнгө оруулалт Монголд хийгдэв. Энэ хөрөнгө оруулалт нь үе дамнах уурхайн үр өгөөжийг бий болгов.



Монгол Улсын Засгийн газар



Монголын арилжааны банкууд



Дотоодын ханган нийлүүлэгчид

**87.3%**



Монгол ажилчид

**97.8%**



ОЮУ ТОЛГОЙН ОЛБОРЛОЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛ

**14** тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт: нэг, хоёрдугаар үе шат

**12.7%**



Олон улсын ханган нийлүүлэгчид

**2.2%**



Гадаад ажилчид



Хөрөнгө оруулагчид



Зээлдүүлэгчид



Худалдан авагчид зээлдүүлэгчдийн шаардлагын дагуу олон улсын банкаар төлбөрөө хийнэ.



### Төслийн санхүүжилтийн эргэн төлөлт

Гүний уурхайн бүтээн байгуулалтад зориулан авсан банкны зээлийг 15 жилийн хугацаанд эргэн төлнө.



### Хувь нийлүүлэгчдийн зээлийн эргэн төлөлт, ногдол ашиг

Үйл ажиллагааны ашгаас хувь нийлүүлэгчдийн зээлийг эргэн төлнө. Зээлийг төлж дуусаад ногдол ашиг хувааж эхэлнэ.

# КОМПАНИЙН УДИРДЛАГА

---



## **ДЭЙРДЭ ЛИНГЕНФЭЛДЕР**

Гүйцэтгэх захирал  
(2025 оны 12 дугаар сар хүртэл)



## **СҮХБААТАРЫН МӨНХСҮХ**

Гүйцэтгэх захирал  
(2026 оны 2 дугаар сараас)

## **ЭНДРЬЮ ЛАЯ**

Үйл ажиллагаа эрхэлсэн захирал

## **БЭГЗЖАВЫН ДУЛАМСҮРЭН**

Санхүү эрхэлсэн захирал

## **ДАШНЯМЫН АМАРБАЯСГАЛАН**

Хууль, эрх зүйн асуудал хариуцсан захирал

## **ЦЭРЭВСҮРЭНГИЙН ЦЭРЭНХҮҮ**

Компанийн хэрэг эрхлэх газрын дарга

## **ЭНХСАЙХАНЫ АНХБАЯР**

Хөрөнгийн удирдлага хариуцсан ерөнхий менежер

## **ПҮРЭВСҮРЭНГИЙН БАЙГАЛМАА**

Бизнес шинэчлэлт, стратеги нэгтгэл хариуцсан ерөнхий менежер

## **МАЛХУУЗЫН ГАНБОЛД**

Баяжуулах үйлдвэр, логистик хариуцсан ерөнхий менежер

## **ДАМИЕН РОЖЕРС**

Гүний уурхайн төслийн удирдагч  
(2025 оны 6 дугаар сар хүртэл)

## **КАЙЛ БАКОЛ**

Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, аюулгүй байдал, орон нутаг хариуцсан ерөнхий менежер  
(2025 оны 11 дүгээр сараас)

## **ЛОРИ ИРВИН**

Боловсон хүчин, бүтэц зохион байгуулалтын ерөнхий менежер  
(2025 оны 3 дугаар сараас)

**ТОГТОХБАЯРЫН ОТГОНБАЯР**

Ил уурхайн үйл ажиллагаа хариуцсан ерөнхий менежер

**БОЛДЫН ӨСӨХБАЯР**

Гүйцэтгэх захирлын тэргүүн зөвлөх

**СТИВЕН КАННИНГ**

Гүний уурхайн төслийн удирдагч  
(2025 оны 6 дугаар сараас)

**СТЕФАН ХЕРСЕЛМЕН**

Гүний уурхайн үйл ажиллагаа хариуцсан ерөнхий менежер

**ГОНЧИГЖАНЦАНГИЙН СУГАР**

Орон нутаг хариуцсан ерөнхий менежер

**ТОММИ КАНКУНЕН**

Уурхайн дэд бүтэц, үйлчилгээ хариуцсан ерөнхий менежер

**ФИЛИП АБРАХАМ**

Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, аюулгүй байдал, орон нутаг хариуцсан ерөнхий менежер  
(2025 оны 11 дүгээр сар хүртэл)

**ФИЛИП БЛАНЧАРТ**

Зэсийн баяжмалын борлуулалтын ерөнхий менежер  
(2025 оны 8 дугаар сараас)

**ХИКМАТ ГАЙБОВ**

Ханган нийлүүлэлт хариуцсан ерөнхий менежер

**ЭНХСАЙХАНЫ ХОНГОРЗУЛ**

Мэдээлэл харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан ерөнхий менежер





## 2025 ОНЫ ТОЙМ

---

2025 он Оюу толгой үйлдвэрийн хувьд онцгой жил байлаа. Үйл ажиллагааны гүйцэтгэлийг санхүүгийн сахилга баттай хослуулан компанийн түүхэнд бичигдэх олон чухал үр дүнд хүрэв. Бид үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэх, бүтээмжээ сайжруулах чиглэлд бодит ахиц гаргаж, салбартаа тэргүүлэгч компани болох зорилгодоо илүү ойртсон, амжилт бүтээлээр дүүрэн нэгэн жилийг үдлээ.

---

Баяжуулах үйлдвэрийн тохируулгын төслийг амжилттай хэрэгжүүлж дуусгасан нь 2025 оны онцлох ажлуудын нэг байв. Энэхүү төсөл нь гүний уурхайн өндөр агууламжтай хүдрийг боловсруулж, металл ялгалтыг сайжруулахын зэрэгцээ үйлдвэрлэх хүчин чадлыг хэвээр хадгалах юм.

Монголдоо анхдагч Гүний уурхайгаас газрын гадарга руу хүдэр тээвэрлэх туузан дамжуургыг амжилттай ашиглалтад орууллаа. Найман километр урт инженерчлэлийн уг шийдэл нь 1,300 метрийн гүнээс өдөрт 95,000 тонн хүдэр тээвэрлэх хүчин чадалтай юм. Энэхүү бүтээн байгуулалт бол манай чадварлаг баг хамт олон, хамтрагч байгууллагуудын сэтгэл, зүтгэлийн илэрхийлэл билээ.

Техник, технологийн шинэчлэл бидний үйл ажиллагаанд голлох байр суурь эзэлсэн хэвээр байна. “Хиймэл оюунт ухаалаг үйлдвэр” системийг уурхай даяар нэвтрүүлж, “Хөрөнгийн хяналтын төв”-ийг байгуулснаар найдвартай байдлын удирдлагыг үндсээр нь шинэ шатанд гаргав. Эдгээр технологи нь эвдрэл



*Гүний уурхайгаас газрын гадарга руу хүдэр тээвэрлэх туузан дамжуурга Хүдэр агуулах байгууламжтай нийлж буй хэсэг*

гэмтлийг урьдчилан тооцож илрүүлэх, төлөвлөгдөөгүй зогсолтыг бууруулах ач холбогдолтой. Үр дүнд нь уурхайд ухаалаг технологи ашиглан аюулгүй тогтвортой, үйл ажиллагааг хангахад хэмжигдэхүйц сайжруулалтыг бий болголоо.

Наймдугаар сард Гүний уурхайн Панель 2-ын анхны “Хүдэр буулгуур”-ын тэсэлгээг төлөвлөгөөнөөс есөн сарын өмнө амжилттай гүйцэтгэв. Энэ нь Гүний уурхайгаас гадарга руу тээвэрлэх туузан дамжуурга, Баяжуулах үйлдвэрийн тав дахь бөмбөлөгт шинэ тээрэм, хоёр дахь Анхдагч бутлуурыг гүний уурхайд ашиглалтад оруулсан зэрэг амжилттай хослон ирэх таван жилд үйлдвэрлэлээ үе шаттай нэмэгдүүлэх суурийг бат тавилаа. Гэвч уурхайн тогтвортой үйлдвэрлэлд онц чухал “Шивээ Толгой”, “Жавхлант” ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг “Оюу толгой” ХХК-д шилжүүлэх асуудал удааширсан тул, 2025 оны зургаадугаар сард уулын ажлын төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулахаас өөр аргагүйд хүрч Панель 1-ийн бүтээн байгуулалтыг түр зогсоож, хүн хүч, техник хэрэгслийг Панель 2 руу шилжүүлэх шаардлага үүсэв.

Үйл ажиллагаанаас гадна, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулж буй хувь нэмэр ч улам бэхжив.

Ажил эрхлэлт, татвар төлөлт, орон нутгийн хөрөнгө оруулалтаар өргөн хүрээний үнэ цэнийг бүтээж, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимаас жил бүр шалгаруулдаг ТОП-100 аж ахуйн нэгжийн жагсаалтад гурав дахь жилдээ дараалан тэргүүллээ.

“Монголд үйлдвэрлэв” гэх зэрэг хөтөлбөрүүдээр дамжуулан 2025 онд орон нутгийн тогтвортой өсөлтийг дэмжиж, дотоодын ханган нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэн, Монгол Улсын тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан ажиллалаа.

Бидний цаашдын зорилго маш тодорхой: аюулгүй, тогтвортой өсөлт. Шаардлагатай суурь нөхцөлүүдээ бүрэн бүрдүүлсэн Оюу толгой үйлдвэр, дэлхийн дөрөв дэх том зэс үйлдвэрлэгч болох замдаа эргэлт буцалтгүй оров. Ингэснээр хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах дэлхий нийтийн хүчин чармайлтад хувь нэмрээ оруулна. 2025 онд гаргасан бидний амжилт нь цаашдын өсөлт хөгжлийг дэмжих суурь болно.

# 2025 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

Таван толгойн нүүрс тээврийн замтай холбосон 12.5 км хатуу хучилттай замыг ашиглалтад оруулав.

7

1,300 метрийн гүнээс хүдэр тээвэрлэх 8 км урт туузан дамжуургын системийг амжилттай угсарч ашиглалтад оруулав.

6

5

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас шалгаруулдаг “Топ 100” аж ахуйн нэгжийн жагсаалтыг “Оюу толгой” ХХК гурав дахь жилдээ дараалан тэргүүлээ.

4

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гаар дамжуулан “Оюу толгой” ХХК-ийн санхүүжилтээр 1,400 хүүхдийн сургууль, цэцэрлэг Даланзадгад хотод баригдав.

“Рио Тинто” компанийн “Аюулгүй, бүтээмжтэй үйл ажиллагааны төлөвшил хөтөлбөр” (Safe Production System)-ийг амжилттай нэвтрүүлэв.

7

3

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Оюу толгойн гүний уурхай, бүтээн байгуулалттай өөрийн биеэр танилцаж, улс орны хөгжил дэвшилд түншлэл, хамтын ажиллагааны чухлыг онцоллоо.

2

Нийт 429 мянган ам.долларын үнэ бүхий нэн шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслийг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газарт хандивлаж ойн санг нэмэгдүүлэх үйл хэрэгт хувь нэмэр орууллаа.

8

Гүний уурхайн Панель 2-ийн хүдэр буулгуурын анхны тэсэлгээг төлөвлөгөөнөөс 9 сарын өмнө амжилттай гүйцэтгэв.

9

Үйлдвэрлэл нэмэгдэхэд чухал ач холбогдол бүхий төслүүд болох Баяжуулах үйлдвэрийн тохируулга болон гүний уурхайн хоёр дахь анхдагч бутлуурыг ашиглалтад оруулах ажлыг амжилттай гүйцэтгэлээ.

10

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 10 жилийн ой болж өнгөрлөө. Өнгөрсөн арван жилийн хугацаанд Өмнөговийн тогтвортой хөгжлийг дэмжих 583 төслийг тус сан хэрэгжүүлжээ.

11

Сэлэнгэ аймагт хариуцлагагүй уул уурхайгаас болж сүйдсэн 60 га талбайд нөхөн сэргээлт хийв.

12

Гүний уурхайн нэг хоногт нийлүүлсэн хүдэр 52 мянган тонн хүрч дээд амжилт тогтоов.



Оюу толгойд цахилгаан өөрөө буулгагч ашиглаж байна.



Технологийн дэвшил болон дүн шинжилгээний цахим арга хэлбэрийг тунгаагуур, хаягдал өтгөрүүлэх, болон хаягдлын далангийн үйл ажиллагаанд бүхэлд нь нэвтрүүлээ.


# ОНЫ ТОВЧООН

## Гэмтэл бэртлийн давтамжийн үзүүлэлт (200,000 хүн/цагт ногдох)



## Баяжмал үйлдвэрлэл

(мян.тонн, хуурай жингээр)  
2025 онд нийт баяжмал үйлдвэрлэл  
1,544 мянган тонн байв.



## Дотоодод зарцуулсан нийт мөнгөн хөрөнгө (2025)

67%

Үндэсний  
компаниудад  
төлсөн  
төлбөр



33%

Улс, орон  
нутгийн төсөвт  
шууд төлсөн  
төлбөрүүд

## Баяжмалын борлуулалт (мян.тонн, хуурай жингээр)

1,632

үүнд 317 мянган тонн (мянган тонн) зэс (2024:  
198 мянган тонн); 44 мянган унц (мянган унц) алт  
(2024: 191 мянган унц)


## Үйл ажиллагааны урсгал капитал зардал

165 сая ам.доллар

## Гүний уурхайн урсгал капитал зардал (ам.доллар)

769 сая ам.доллар

## Татвар, хураамж болон бусад төлбөр (2010 - 2025 он, сая ам.доллар)




2010 оноос хойш татвар, хураамж, үндэсний компаниудад төлсөн НӨАТ зэрэг бусад төлбөрт 5.5 тэрбум ам.доллар төлсөн. 2025 онд татвар, хураамж бусад төлбөрт 660 сая ам.доллар төлжээ.

\* "Оюу толгой" ХХК НӨАТ-ын буцаан авалт хийдэггүй.

\*\* Энэ дүнд олон улсын арбитраг хэлэлцэж буй 356 сая ам.долларын төлбөр багтсан болно.

## Оюу толгой үйлдвэрийн борлуулалтын орлого

(сая ам.доллар)



## Дотоодын худалдан авалт

(Өмнөговь аймаг, сая ам.доллар)

2010-2025

2025

# 2,049 | 329


2025 онд Өмнөговь аймагт бүртгэлтэй 105 ханган нийлүүлэгч 329 сая ам.долларын бараа материал, ажил үйлчилгээ үзүүлэв. 2010 оноос хойш Өмнөговь аймгаас нийт 2 тэрбум ам.долларын бараа, үйлчилгээг “Оюу толгой” ХХК худалдан авчээ.

## Дотоодын худалдан авалт

(Улсын хэмжээнд, 2010 оноос)

# 14.2 тэрбум ам.доллар

2025 онд Үйл ажиллагааны худалдан авалтын баг 1,090 ханган нийлүүлэгчтэй хамтран ажилласны 770 нь үндэсний компани байв. Эдгээр үндэсний компанид худалдан авалтынхаа 87 хувийг зарцуулав. 2010 оноос хойш үндэсний худалдан авалтад 14.2 тэрбум ам.доллар зарцуулсан байна.



# 86.5%

2025 оны эцсийн байдлаар ус дахин ашиглалтын зорилт болох 80 хувиа давуулан 86.5 хувьд хүргэлээ.

## Ус ашиглалтын төлбөр

(2013-2025)

# 79.4 сая ам.доллар

# 4,719

“Оюу толгой” ХХК-ийн нийт ажиллах хүч



# 24%

эмэгтэй ажилчид

Хүйсийн тэгш байдлын хувьд Оюу толгой үйлдвэр дэлхийн дундаж болох 15% хувиас харьцангуй өндөр байна. (Дэлхийн банк, 2024).





# ДЭЛХИЙН ЭНТЭЙ ЗЭСИЙН БИЗНЕСИЙГ ЦОГЦЛООХ НЬ





## ҮЙЛДВЭРЛЭЛ

---

Баяжмал дахь зэс  
үйлдвэрлэл

**345,199** тонн

---

Баяжмал дахь алт үйлдвэрлэл

**455,864** унц

---

Баяжмал дахь мөнгө үйлдвэрлэл

**2,179,862** унц

---

Нийт борлуулсан баяжмал  
(нойтон жингээр)

**1,632** мянган тонн

2025 онд Оюу толгой зэсийн нийлүүлэлт болон санхүүгийн гүйцэтгэл түүхэн дээд түвшинд хүрч, 2024 онтой харьцуулахад зэсийн үйлдвэрлэл 61 хувь, алтных 121 хувиар нэмэгдэв. Ингэснээр зэс үйлдвэрлэлийг өнгөрсөн оноос 50 хувиар өсгөх төлөвлөгөөгөө биелүүлэв.

Баяжуулах үйлдвэрийн тохируулгын төсөл болон Гүний уурхайгаас газрын гадарга руу хүдэр тээвэрлэх туузан дамжуурга зэрэг бүтээн байгуулалтын томоохон төслийг амжилттай хэрэгжүүлж, ашиглалтад оруулсан нь үйлдвэрлэл оргил үедээ хүрэхэд түлхэц үзүүлэх томоохон алхам болов. “Хиймэл оюунд суурилсан Ухаалаг үйлдвэр” зэрэг дэвшилтэт технологиудыг нэвтрүүлснээр хөрөнгийн удирдлагыг сайжруулж, зэс, алтны үйлдвэрлэл тогтвортой өссөн. Эдгээр амжилт нь санхүүгийн сахилга бат, стратегийн хөрөнгө оруулалттай хослон Монгол Улс болон хувь нийлүүлэгчдэд тогтвортой үнэ цэнэ хүргэх зорилтод чухал үүрэг гүйцэтгэж байна.

Баяжмал дахь зэсийн үйлдвэрлэл 345,199 тоннд хүрсэн нь чухал дэд бүтэц ашиглалтад орж, гүний уурхайн олборлолт нэмэгдсэнтэй холбоотой.

Үйлдвэрлэл болон борлуулалтын тойм	2023	2024	2025
Зэс үйлдвэрлэл (мянган тонн, хуурай жин)	796	994	1,544
Тээвэрлэлт (мянган тонн, нойтон жин)	860	1,072	1,647
Баяжмал борлуулалт (мянган тонн, нойтон жин)	891	1,042	1,632
Зэс борлуулалт (мянган тонн)	166	198	317
Алт борлуулалт (мянган унц)	175	191	414
Зэсийн бодит үнэ (цент/фунт)	387	422	458
Алтны бодит үнэ (ам.доллар/унц)	1,941	2,426	3,608





## ГҮНИЙ УУРХАЙ

2025 онд гүний уурхайн үйл ажиллагаанд хэд хэдэн чухал амжилт гарав. Тухайлбал, арванхоёрдугаар сард хоногт дунджаар 42 мянган тонн олборлож, нэг өдрийн дээд амжилт 52 мянган тоннд хүрэв. Эдгээр амжилт нь Материал зөөвөрлөх систем болон гүний уурхайн ачилтын тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа, гүний уурхайн чадварлаг багийн ажлын гүйцэтгэл сайн байсныг илтгэнэ.

Гүний уурхайн бүтээн байгуулалтын хэсэг болох Панель 2-ын анхдагч хүдэр буулгуурын тэсэлгээг төлөвлөгөөнөөс есөн сарын өмнө амжилттай гүйцэтгэснээр шинэ хүдрийн бүсэд нэвтрэх хугацааг наашлуулсан нь ирээдүйн үйлдвэрлэлд чухал ач холбогдолтой үйл явдал байлаа. “Онтрэ” компанийн эзэмшлийн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлаас үүдэн гүний уурхайн хөндлөн нэвтрэлтийн дарааллыг дахин төлөвлөх шаардлагатай болсон ч үйлдвэрлэлийн хэмжээ тогтвортой өсөж, 2028-2036 оны хооронд жилд дунджаар 500 мянган тоннд хүргэх төлөвлөгөөтэй хэвээр ажиллаж байна. Гүний уурхайн хоёрдахь Анхдагч бутлуурыг ашиглалтад оруулсан нь үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Харин гүний уурхайгаас газрын гадарга руу хүдэр тээвэрлэх 8 километр урт туузан дамжуурга нь хоногт 95,000 тонн хүдэр тээвэрлэх нөхцөл боломжийг бий болголоо. Гүний уурхайн төслийн бүтээн байгуулалт дуусан олборлолт эрчимжсэнээр Монгол Улсын эдийн засагт оруулах ирээдүйн хувь нэмэр улам бэхэжнэ.



## ИЛ УУРХАЙ

Ил уурхайн үйл ажиллагаа нь ил болон гүний уурхайгаас баяжуулах үйлдвэрт харилцан адилгүй зэсийн агууламжтай хүдрийг тэнцвэртэй нийлүүлэхэд төвлөрөв. Түүнчлэн уурхайн гүн нэмэгдэхийн хэрээр геотехникийн нөхцөлийг аюулгүй удирдан, техник, олборлолтын найдвартай ажиллагааг хангаж ажиллав. Ил уурхайгаас зөөвөрлөсөн чулуулгийн хэмжээ 2025 онд 99.8 сая тоннд хүрсэн, том оврын өөрөө буулгагчийн дундаж ашиглалт 74.6 хувь байсан нь өндөр үзүүлэлт юм.

Ил уурхайн өөрөө буулгагчийн нэг удаагийн ачилтын жингийн үзүүлэлт Рио Тинтогийн бусад уурхайг тэргүүлэхүйц буюу 101.7 хувь байв. Энэ нь уулын ажиллах дарааллын өөрчлөлтөөс шалтгаалан хурдан эргэлттэй материалын эзлэх хувь нэмэгдэж, жингээр бус багтаамжаар хязгаарлагдах горимд шилжсэнтэй холбоотой. Гэвч нийт өөрөө буулгагчийн үйл ажиллагааны бэлэн байдал 88.7 хувь байсан нь дээрхээс үүссэн сөрөг нөлөөг бууруулахад чухал нөлөө үзүүлсэн бөгөөд энэ нь Засварын багийн хүч хөдөлмөрийн үр дүн юм.

Тайлант хугацаанд хэд хэдэн цахилгаан үүсгүүрт өөрөө буулгагчийг ил уурхайн үйл ажиллагаанд туршиж эхлэв. Шинээр ашиглалтад орсон зай хураагуур солих станцууд цэнэглэх хугацааг долоон минут хүртэл бууруулж байгаа нь хүлэмжийн хийг тэглэх бидний зорилтод чухал нөлөө үзүүлж байна.



## БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР

Баяжуулах үйлдвэрийн тохируулгыг амжилттай гүйцэтгэж дууссанаар гүний уурхайн өндөр агууламжтай хүдрийг баяжуулах процесст томоохон дэвшил гарав. Энэ хүрээнд хөвүүлэн баяжуулах хүчин чадлыг нэмэгдүүлж, илүү нарийн нунтаглах тав дахь бөмбөлөгт тээрмийг суурилууллаа. Эдгээр шинэчлэл нь техникийн сайжруулалтын хамт, хүдрийн шинж чанар өөрчлөгдөх үед ч баяжуулах үйлдвэрийн боловсруулах хүчин чадлын ашиглалтыг дээд түвшинд байлгах юм.

Баяжуулах үйлдвэр гүний уурхайн хатуулаг өндөр хүдэр боловсруулж буй ч хүдэр боловсруулалт 41.4 сая тоннд хүрч, үйлдвэрийн үр ашигтай ажиллагаа 95.1 хувь байгаа нь үйлдвэрийн тохируулгын төслийг амжилттай хэрэгжүүлсэнтэй холбоотой юм. Баяжмал үйлдвэрлэл 1,544 мянган тоннд хүрснээр, логистик, тээвэрлэлтийг шинэ дээд амжилтыг тогтоов.


Зэс ялган авалтын дундаж 86.1 хувьд хэлбэлзэж, зорилтот хэмжээнд хүрээгүй ч зэсийн агуулга нэмэгдсэн тул төлөвлөлт үйлдвэрлэлийн хэмжээндээ хүрч чадлаа. Алт ялгалт 68.9 хувь байсан нь төлөвлөгөөнөөс доогуур үзүүлэлт бөгөөд холимгийн нарийн төвөгшил, ялангуяа Ил уурхайн Төв хүдрийн тэжээл дэх пиритийн агууламж (зэсийн агуулга өндөртэй) нь баяжуулалтад сорилт үүсгэв. Үүнийг шийдэх зорилгоор металл ялгалтыг сайжруулах багц санаачилгуудыг тодорхойлон хэрэгжүүлж эхлээд байна.



## ЗЭСИЙН БАЯЖМАЛ ҮЙЛДВЭРЛЭЛ

(мянган тонн)

ХҮРТЭХ ӨГӨӨЖ - ҮЙЛДВЭРЛЭЛ





Савлах үйлдвэрээс хэрэглэгчдийн зүг

## **ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛЭЭР ДАМЖУУЛАН НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГАА, ӨСӨЛТ ХӨГЖЛИЙГ БИЙ БОЛГОХ НЬ**

2025 онд тоног төхөөрөмжийн эвдрэлийг урьдчилан илрүүлж, төлөвлөгдөөгүй зогсолтоос сэргийлэх зорилгоор “Хиймэл оюунд суурилсан Ухаалаг үйлдвэр” системийг Оюу толгойн уурхайд бүрэн нэвтрүүллээ. Энэхүү систем нь 300 гаруй нэн чухал тоног төхөөрөмжийг хянах бөгөөд шинээр суурилуулсан 2,759 нэгж чичиргээ болон температур мэдрэгч нь өмнө нь ашиглагдаж байсан 5,607 мэдрэгчтэй уялдан ажиллах юм.

Хэвийн бус ажиллагааг эрт илрүүлж засварлах, шаардлагатай арга хэмжээ авах зөвлөмж өгснөөр 2025 онд ойролцоогоор 15 сая ам.долларын зардал хэмнэгдэж, эвдрэл хоорондын дундаж хугацааг мэдэгдэхүйц уртасган, үйлдвэрийн бэлэн байдлыг сайжруулав.



### Шинээр байгуулагдсан Хөрөнгийн хяналтын төв

Хөрөнгийн хяналтын төв нь мэдээллийг зогсолтгүй хүлээн авч нэгтгэн, авах арга хэмжээний зөвлөмжийг хяналтын самбарт шууд дамжуулан харуулснаар, төлөвлөгөөт зогсолтын хугацааг нарийн товлох, сэлбэг, эд ангийн насжилтыг уртасгахад дэмжлэг үзүүлдэг. Эдгээр технологи нь засвар үйлчилгээний нарийвчилсан стратеги төлөвлөгөө, нөөц сэлбэгийн удирдлагатай хавсран нэгж өртгийг бууруулж, үйлдвэрлэлийг тогтвортой болгодог ач холбогдолтой.

Үйл ажиллагааны удирдлагын сайжруулалтыг хөвүүлэн баяжуулалт, өтгөрүүлэлт, хаягдлын боловсруулах системд амжилттай нэвтрүүлэв. Хүдрийн төлөвлөлт, агуулгын хяналттай уялдуулах нь холимгийн чанарыг сайжруулж, металл ялгалтыг тогтворжуулдаг. Гүний уурхайн ачаалал нэмэгдэхийн хэрээр материал зөөврийн өгөгдлийг хэмжигч нь туузан дамжуургын ачааллыг тэнцвэржүүлж, бөглөрлөөс урьдчилан сэргийлэх удирдлагыг сайжруулснаар сул зогсолтыг бууруулж, хүдэр буулгуурын дарааллыг оновчтой болгодог. Өөр хоорондоо нягт хамааралтай эдгээр жижиг мэт боловч өндөр ач холбогдолтой сайжруулалтууд нь боловсруулалт болон бусад гүйцэтгэлийн үнэлгээнд жинтэй нөлөө үзүүлдэг.



Оюу толгойн Ил хуваарилах байгууламж

## ЭРЧИМ ХҮЧ

Оюу толгой үйлдвэрийн эрчим хүчний хэрэглээ үйл ажиллагааны онцлогоос хамааран харьцангуй өндөр бөгөөд гүний уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллахад 200 гаруй МВт эрчим хүч хэрэгцээтэй юм. Уурхайн үйл ажиллагааны зардлын хоёрт бичигдэхүйц томоохон дүнг эрчим хүчинд бид зарцуулдаг. Эрчим хүчний байнгын, найдвартай, тогтвортой эх үүсвэр нь ажилчид, үйлдвэрлэлийн нөөц, уурхайн бүхий л дэд бүтэц төдийгүй санхүүгийн нөөцийг эрсдэлээс хамгаалахад нэн чухал билээ.

Монгол Улсын Засгийн газар (Эрчим хүчний яам, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ, Диспетчерийн үндэсний төв) болон “Оюу толгой” ХХК нь Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс Оюу толгой төслийг урт хугацаанд эрчим хүчээр хангах гэрээг 2022 оны 1 дүгээр сард байгуулсан бөгөөд эрчим хүчний нэгдсэн сүлжээ найдвартай, тасралтгүй эрчим хүч нийлүүлэх боломжтой болмогц энэхүү гэрээ хэрэгжиж эхэлнэ. Нэгдсэн сүлжээ бэлэн болох хүртэл импортын гэрээний дагуу Өвөр Монголын сүлжээнээс эрчим хүчээр хангагдана.

Өвөр Монгол–Оюутолгой уурхайг холбосон цахилгаан дамжуулах шугамыг ашиглан Монголын улсын Төвийн бүсийн эрчим хүчний систем (ТБЭХС)-д эрчим хүч нэмэлтээр импортлох зорилгоор “ЗэсОюу” ил хуваарилах байгууламжийн шийдлийг 2024-2025 онд “Оюу толгой” ХХК-ийн санхүүжилтээр хэрэгжүүлж байна.

Цаашид эрчим хүчний нэгдсэн сүлжээгээр дамжсан дотоод эх үүсвэрт үе шаттай шилжих болон сэргээгдэх эрчим хүч ашиглах техникийн болон эдийн засгийн боломжийг үргэлжлүүлэн судална. Өмнийн говийн нар, салхины эх үүсвэрийг зай хураагууртай хослуулан хэрэглэх, шилжилтийн үед импортын эх үүсвэрийг нөөц байдлаар хадгалах замаар аюулгүй, өртөг багатай, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт шилжих зорилго тавин ажиллаж байна.

## АЧАА ТЭЭВЭР

2025 онд баяжмал тээвэрлэлт 1,647 мянган тоннд хүрч, жилийн төлөвлөгөө болон 2024 оны 1,072 мянган тонны түвшинг давуулан биелүүлэв. Энэ гүйцэтгэл нь үйлдвэрлэл өндөр байсан, газар дээрх борлуулалтын эзлэх хувь нэмэгдсэн, борлуулалтын бүтэц, болон экспортын зохион байгуулалтын сахилга бат сайжирсны үр дүн юм. Бид нэгдүгээр сараас арванхоёрдугаар сар хүртэл 17 цувааг төлөвлөгөөний дагуу гаргаж хүчин чадлаа бүрэн дүүрэн ашигласан ба долоо хоногийн оргил хэлбэлзлийг намжааж, хил дээрх сул зогсолтыг бууруулж, сарын эцсийн ачилтыг тогтвортой байлгав. Логистикийн түншүүдтэй цагийн төлөвлөлтийг илүү нягт уялдуулж, гаалийн хуваарь болон овоолгын удирдлагыг сайжруулснаар агуулахын ачааллыг үйлдвэрийн дамжуулалттай нийцүүлж, нэг удаагийн огцом өсөлтөөс илүү тогтвортой давтамжийг чухалчилж, эргэлтийн хугацаа болон хүргэлтийн чанарыг хадгалсан.





# ШИЛДЭГ АЖИЛ ОЛГОГЧ БАЙНА





## ХАМТ ОЛОН

---

Гэмтэл бэртлийн  
давтамжийн  
үзүүлэлт

**0.22**

Аюулгүй  
ажиллагааны  
төлөвшлийн үнэлгээ

**6.1**

---

Эмэгтэй ажилчдын  
эзлэх жин

**24%**

Эмэгтэй удирдах  
ажилчид

**23.6%**

---

Ажилчдын сэтгэл  
ханамжийн үнэлгээ

**85**

Ажиллах хүчний  
сургалт, давтан  
сургалтад хамрагдсан  
байдал (хүн/цаг)

**876,731**


---

Нийт олгосон тэтгэлэг (2010-оос)


**1,375**

Карьер хөгжлийн хөтөлбөрт  
хамрагдагсад (2013-оос)

**1,617**



## МОНГОЛ АЖИЛЧДЫН ЭЗЛЭХ ХУВЬ СҮҮЛИЙН ДОЛООН ЖИЛИЙН БАЙДЛААР



Оюу толгой үйлдвэрийг дэлхийн жишиг уурхай болгоход манай хамт олон онцгой үүрэг гүйцэтгэдэг. Харилцан хүндлэл, тэгш оролцоо, шинийг эрэлхийлж суралцах зан чанарт тулгуурласан ажлын соёлд түшиглэн үндсэн болоод гэрээт ажилчдаас бүрдсэн Оюу толгойчууд хөгжил дэвшлийг хамтдаа бүтээх хэтийн зорилгоо ажил хэрэг болгоход оюун ухаан, эрдэм мэдлэг, хүч хөдөлмөрөө дайчлан ажиллаж байна. Дэлхийн тавцанд өрсөлдөх чадвартай боловсон хүчнийг дотооддоо бэлтгэхэд компанийн зүгээс хүчин чармайлт гаргаж буй бөгөөд 2025 оны байдлаар манай хамт олны 97.8 хувь нь монгол ажилчдаас, харин 24.2 хувь нь Өмнөговь аймгийн ажилчдаас бүрдэж байна.

## ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, САЙН САЙХАН БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ НЬ

Аюулгүй ажиллагаа бол үйл ажиллагааны хэмжүүр төдий бус Оюу толгой үйлдвэрийн баталсан стратеги, гаргасан шийдвэр, гүйцэтгэж буй ажил бүрт шингэсэн, бидний чанд баримталдаг ажлын хандлага юм.

Өнгөрсөн жил манай Гэмтэл бэртлийн давтамжийн үзүүлэлт 0.22 байсан нь зорилтот тааз болон салбарын дунджаас доогуур үзүүлэлт юм. Ингэснээр бид аюулгүй ажиллагаагаар үргэлжлүүлэн манлайлж Рио Тинтогийн уурхай дундаас хамгийн аюулгүйн нэг болохоо дахин баталлаа.


Оюу толгой үйлдвэр нь хэдийгээр Монгол Улсад салбартаа тэргүүн эгнээнд бичигдэх аюулгүй ажиллагаатай ч үүнийгээ улам сайжруулахын төлөө цаг ямагт санаа тавьж, тийм ажлын соёлыг бэхжүүлэхийг зорьж байгаа болно.

“Ажлаа зогсоож тусламж хүсэх”, “Аюулгүй ажиллагааны төлөвлөгөөт зогсолт”, “Аюулгүй ажиллагааны ярилцлага”, болон “Ажлын талбар дээрх манлайлал” зэрэг санаачилга нь эрсдэлийг урьдчилж тодорхойлох, аюулгүй ажиллагааны эрсдэлийг нээлттэй, ил тод хэлэлцэх идэвхийг нэмэгдүүлэх замаар аюулгүй ажиллагааны төлөвшлийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулж байна.

Амь насанд аюултай, олныг хамарсан осол гарах эрсдэлийг аль болох бууруулах зорилгоор уурхайн талбарт ажиллаж буй удирдах ажилчид 2025 онд нийт 14 мянга гаруй ноцтой ослын эрсдэлд хяналт тавьж ажиллалаа.

### Гэмтэл бэртлийн давтамжийн үзүүлэлт (AIFR)

(200,000 хүн/цагт ногдох)



**Зорилт:**  
**Үзүүлэлтийг**  
**0.23-аас бага**  
**байлгах**





Оюу толгойн ажилчид болон тэдгээрийн гэр бүлд зориулсан “Ханбогд” хотхон

## **АЖИЛЧДЫН АМЬДРАХ ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ НЬ**

Хамт олондоо санаа тавих нь тэдний өдөр тутмын амьдрах нөхцөлийг тасралтгүй сайжруулахаас эхэлнэ. Ажилчдын санал хүсэлтээс үзэхэд хоолны сонголт, эрүүл мэндэд чиглэсэн хөтөлбөрүүд, амьдрах орчны чанар мөн алжаал ядаргааны менежментийг сайжруулах хүсэлтүүд нийтлэг тохиолддог. Эдгээр нь ажилчдын дунд хийгдсэн судалгаа болон ажилчидтай хийдэг уулзалтуудад хөндөгддөг түгээмэл сэдвүүд юм.

Ажилчдын орон байрны асуудлыг шийдвэрлэх Оюу толгой үйлдвэрийн урт хугацааны стратеги нь хоёр үндсэн зорилтоос бүрддэг. Үүнд, урт хугацааны үйл ажиллагааны цар хүрээнд нийцсэн тогтмол ирж, очдог ажилчдын байнгын орон байрыг бий болгох, хоёрдугаарт, ажиллах хүчний амьдрах, суурьших төлөвлөлтийг Ханбогд сумын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулах явдал юм.



*Оюу толгойн ажилчид болон тэдгээрийн гэр бүлд зориулсан “Ханбогд” хотхон*

Өргөн хүрээг хамарсан энэхүү зорилтын хүрээнд Оюу толгой компани Улаанбаатараас уурхайн талбар руу нисэж ирж очих ээлжийн тоог мэдэгдэхүйц цөөрүүлж, харин орон нутагт ажиллаж амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх өргөн далайцтай зорилт дэвшүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд бид 2035 он гэхэд нийт ажиллах хүчний тэн хагасыг ажилдаа Ханбогд сумаас очдог болгох зорилт тавьсан. Хэдийгээр 2025 оны зорилтот түвшин болох 7 хувьд хүрээгүй ч Ханбогдоос ажилдаа явж буй ажилчдын эзлэх хэмжээ 4.4 хувьд хүрсэн нь энэ чиглэлд ахиц гарч буйг илтгэнэ.

Дээрх зорилгын хүрээнд Оюу толгой компани засвар үйлчилгээ их шаардах одоогийн “сэндвичэн” барилгуудыг үе шаттай халж оронд нь ажилчдад зориулсан байнгын орон сууцны цогцолборыг босгоно.

2025 онд ээлжийн дундуур орон байр солихыг тэглэх, нэг өрөөнд гурван ажилтан хуваарилагддаг байдлыг 15 хувиар бууруулах зорилго тавин ажилласан. Эдгээр чиглэлд тодорхой ажил, арга хэмжээ хэрэгжүүлсний дүнд 2024 онд ээлж дундуур байр солих 350 тохиолдол бүртгэгдэж байсныг 2025 онд тэглэсний зэрэгцээ гурван хүн дундаа өрөө ашиглахыг 26 хувь бууруулж төлөвлөгөөгөө давуулан биелүүллээ.



Цаашилбал, дөрвөн блокоос бүрдэх 5 давхар, бүрэн цутгамал орон сууцны шавыг уурхайн цогцолборт тавив. Нийт 1,120 нэгж нэг хүний өрөө бүхий барилгын бүтээн байгуулалтын ажил эхэлснээр ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлэх Оюу толгой үйлдвэрийн урт хугацааны стратеги гараанаас гарлаа. Төсөл хэрэгжсэнээр ажилчдын байнгын орон сууцны тоог аажмаар нэмэгдүүлж харин өрөө дундаа ашиглах явдлыг бууруулснаар ажилчид тав тухтай ажиллаж амьдрах боломжоор хангагдах юм.

Оюу толгой үйлдвэр бол ганц ажлын байр бус нэг баг хамт олон, өнөр өтгөн гэр бүл. Ажилчдадаа бид олон тооны шаардлагатай үйлчилгээ тухайлбал, номын сан, бялдаржуулах

төв, цагийг үр бүтээлтэй өнгөрөөх орон зай, уурхай доторх такси үйлчилгээ, кофе шоп, банк, эмийн сан болон эмнэлэг гэх зэрэг бусад нэн шаардлагатай үйлчилгээ авах боломжоор хангадаг.

Үүний зэрэгцээ, Үндэсний их баяр наадам, Сар шинэ, жил бүрийн гэр бүлийн өдөрлөг зэрэг тэмдэглэлт баяр, соёлын өдөрлөг, арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг нь ажил, амьдралын тэнцвэрийг хадгалахад чухал үүрэгтэй. Аюулгүй бөгөөд таатай ажлын орчныг бүрдүүлэх зорилгод эдгээр төсөл хөтөлбөр, санаачилга нь ажилтны сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, сайн сайхан байдлыг хангахад дэмжлэг болдог.



Шинэ байнгын орон сууцны цогцолбор (төслийн зураг)



Эмэгтэй ажилчдын  
эзлэх хувь

**24%**


Зорилт: 25%

## ОЛОН ТАЛТ БАЙДАЛ, ТЭГШ ОРОЛЦООГ ХАНГАХ НЬ

Аюулгүй бөгөөд олон талт байдлыг хангасан соёлыг хүндэтгэлтэй харилцаа, тууштай манлайлал, дуу хоолойгоо айх аюулгүй илэрхийлэх итгэлцэл улам бэхжүүлдэг. Жилд хоёр удаа явуулдаг Ажилчдын судалгааны үр дүн хүндэтгэл, оролцоо, хамт олны нэг хэсэг байх, мөн дуу хоолойгоо илэрхийлэх тал дээр ахиц гарч буйг харууллаа. Судалгаагаар ажилчдын сэтгэл ханамжийн үзүүлэлт 2025 онд 85 болж, өмнөх оныхоос 9 оноогоор өссөн байна.

Жилийн турш нийт ажилчдын 100 хувь нь “Өдөр бүр хүндэтгэе” хөтөлбөрийн сургалтад хамрагдаж, удирдах ажилтнуудын 92 хувь нь тусгайлсан сургалтын хөтөлбөрийг дүүргэсэн

## АЖИЛЛАХ ХУЧИН ДУНДАХ ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАРЬАТ ИРГЭДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ



байна. Гэхдээ сургалтын өндөр хамрагдалтыг хандлага, зан үйлийн бодит өөрчлөлт болгоход бид гол анхаарлаа хандуулна.

Хүндлэл болон оролцоог хангах баг Оюу толгой дахь бүх хэлтэс, нэгжийг хамарсан Ажлын байрны дээрэлхэлтийн талаарх мэдлэг түгээх аяныг зохион байгуулж, ажилчдад зориулсан гарын авлага, удирдах ажилтнуудад зориулсан харилцааны багц танилцуулга, үндсэн болон гэрээт түншүүдийн 400 гаруй удирдах ажилтныг хамруулсан хэлэлцүүлэг зохион байгуулав. Эдгээр санал санаачилга, ажил арга хэмжээ нь асуудлыг шийдвэрлэхэд хамт олны төлөвшил, тууштай байдлыг цаашид бэхжүүлэх хэрэгцээ шаардлага байгааг харууллаа. Хортой зан үйл эсвэл түүнээс учрах сөрөг нөлөөний анхны шинж тэмдэг илэрсэн даруйд даруй арга хэмжээ авч, даамжралыг бууруулахын тулд ажилтнууд Халамж, тусламжийн төвд хандах боломжтой юм. Тус төв нь харилцааг сайжруулах, багийн эрүүл мэндийн үнэлгээ, эвлэрүүлэн зуучлах, багийн сургалт авах зэрэг боломжуудыг санал болгодог.

Гомдол мэдээлэх, хүлээн авах үр дүнтэй механизм нь байгууллагадаа итгэх итгэлийн чухал хэмжүүр билээ. Оюу толгойн “myVoice” суваг нь “Бидний үнэт зүйлс ба ёс зүйн дүрэм”-тэй үл нийцэх зан үйлийг нэрээ нууцлан мэдээлэх боломжийг олгодог.

## АЖИЛЧДЫН УР ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

Бид дэлхийд танигдсан дотоодын ажиллах хүчийг бий болгохыг зорьж буй. Өнгөрсөн жил нийт 876,731 хүн/цаг сургалтад манай хамт олон хамрагджээ. Сургалтууд нь гүний уурхайн үйл ажиллагаа, өндөр эрсдэлтэй ажлын аюулгүй ажиллагаа, болон мэргэшлийн зэрэг олгох сургалтууд гэх мэт өргөн хүрээг хамардаг. Ажлын байран дээр сургах болон дадлагажигч хөтөлбөрт 227 ажилтан, 22 дадлагажигч хамрагдаж механикч, гагнуурчин болон цахилгаанчин зэрэг эрэлттэй мэргэжлээр суралцаж олон улсад хүлээн зөвшөөрөгдөх батламж гардан авлаа.

Компанийн тэтгэлэгт хөтөлбөрүүд улс орны ирээдүйн уул уурхайн мэргэжилтнийг бэлтгэхэд хувь нэмрээ оруулсаар байна. Энэ хүрээнд 2025 онд нийт 117 дотоод болон гадаад тэтгэлэг гардуулснаар 2010 оноос хойш тэтгэлэгт хөтөлбөрөөр суралцагсад 1,375-д хүрэв. Тэтгэлэг хүртсэн залуус инженер, оператор, уул уурхайн мэргэжил эзэмшиж буй нь Оюу толгой үйлдвэрийн ирээдүйн тогтвортой үйл ажиллагаанд дэмжлэг болоод зогсохгүй Монгол Улсын уул уурхайн хөгжилд чухал ач холбогдолтой юм.

“Оюу толгой” компани нь ажилчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ирээдүйн уул уурхайн мэргэжилтнүүдийг бэлтгэх гэх зэргээр боловсролын салбарт 2025 оны байдлаар нийт 152 орчим сая ам.долларын хөрөнгө оруулаад байна.





Дотоодын  
тэтгэлэг

511

Гадаад  
тэтгэлэг

49



52

Малчдын  
хүүхдийн  
тэтгэлэг

763

Говийн Оюу  
ХДС-гийн  
тэтгэлэг





# ХӨГЖИЛ ДЭВШЛИЙН ТҮНШ БАЙНА



# ХАМТЫН АЖИЛЛАГАА

Нийт ханган  
нийлүүлэгчид

**1,090**

Дотоодын ханган  
нийлүүлэгчид

**770**

Өмнөговь аймгийн ханган  
нийлүүлэгчдээс авсан худалдан  
авалтын нийт дүн (2010-2025)

**2 тэрбум ам.доллар**

Дотоодын худалдан авалтад  
зарцуулсан нийт дүн (2010-2025)

**14.2 тэрбум ам.доллар**

Дотоодын худалдан авалтын эзлэх хувь

**87%**

“Оюу толгой” ХХК бол үндэсний ашиг сонирхол болон олон улсын уул уурхайн мэдлэг туршлагыг холбосон Монгол Улсын Засгийн газар болон “Рио Тинто” компанийн стратегийн түншлэл юм. Өнгөрсөн 15 жилийн хугацаанд уурхайн үйл ажиллагаа тасралтгүй өргөжиж зэсийн цогц бизнес болж хөгжөөд байна.

Үйл ажиллагаа нь эхэлсэн цагаас хойш энэхүү түншлэлийн загвар санхүүгийн бөгөөд нийгэм, эдийн засгийн үр өгөөжөө өгч улс орны эдийн засгийг бэхжүүлэх, шинээр ажлын байр бий болгох, дэд бүтцийг хөгжүүлэх, орон нутгийн эдийн засгийн болоод бусад чадамжийг сайжруулах, сөрөн тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулж ирлээ.

Өнгөрсөн оны хувьд ч нягт хамтын ажиллагаа, түншлэл Оюу толгой үйлдвэрийн амжилт бүтээлийн

хөдөлгөгч хүч байв. Монгол Улсын Засгийн газар, орон нутгийн иргэд, ханган нийлүүлэгчид болон бусад түншлэгч талуудын өгөөмөр дэмжлэг, нягт хамтын ажиллагааны ачаар хувь нийлүүлэгчид болон түншлэгч талуудад Оюу толгой үйлдвэрийн өгөөжийг урт хугацаанд тогтвортой авчрах зорилгод ахиц гарсаар байна.

Бидний энэхүү зорилгод уурхайн цогцолбортой хамгийн ойр орших Ханбогд сумын хөгжилд дэмжлэг үзүүлэх, Өмнөговь аймгийн хатуу болон зөөлөн дэд бүтцэд хувь нэмрээ оруулах зорилт мөн багтдаг. Үүний зэрэгцээ боловсрол, залуусын хөгжил, эрүүл мэнд зэрэг салбарт хөрөнгө оруулахаас гадна улс орны хөгжил цэцэглэлд хувь нэмэр болох төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, санаачилга гарган ажиллаж байна.

## ДОТООДОД ЗАРЦУУЛСАН НИЙТ МӨНГӨН ДҮН (2025)



67%

Дотоодын ханган нийлүүлэгчид, ажилчдын цалинд

1,066

сая ам.доллар (НӨАТ ороогүй)

33%

534 сая ам.доллар (НӨАТ ороогүй)

Татвар, хураамж болон бусад төлбөр хэлбэрээр Монгол Улсын Засгийн газарт

Орон нутгийн ханган нийлүүлэгчдээс худалдан авсан худалдан авалт (Өмнөговь)

2,049 сая ам.доллар

329

сая ам.доллар

2025 онд орон нутгийн 105 ханган нийлүүлэгч 329 сая ам.долларын үнэ бүхий бараа материал, ажил үйлчилгээг “Оюу толгой” ХХК-д нийлүүлсэн бол 2010 оноос хойших нийт хугацаанд энэ үзүүлэлт 2 тэрбум ам.доллар давжээ.

## БАТ БӨХ ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭГ БИЙ БОЛГОХ НЬ

26%

Олон улсын ханган нийлүүлэгч



74%

Дотоодын ханган нийлүүлэгч

Дотоодын аж ахуйн нэгжүүдийг дэмжих нь манай худалдан авалтын стратегийн цөм хэсэг юм. 2025 оны байдлаар компанийн нийт худалдан авалтын 87 хувийг дотоодын ханган нийлүүлэгчдээс хийж орон нутгийн болон улс орны эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулах зорилгоо батлан харууллаа. Тайлант хугацаанд нийт 1,090 ханган нийлүүлэгчтэй хамтран ажилласны 770 нь үндэсний аж ахуйн нэгж байв. “Монголд үйлдвэрлэв” зэрэг хөтөлбөр нь үндэсний худалдан авалтад түлхүү анхаарахад түлхэц үзүүлж, импортыг орлох, орон нутгийн үйлдвэрлэлийн чадавхыг нэмэгдүүлж инновацыг идэвхжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна.

2010 оноос хойш Оюу толгой компани дотоодын аж ахуйн нэгжүүдээс нийт 10 тэрбум гаруй ам.долларын худалдан авалт хийж нийт худалдан авалтаас дотоодын аж ахуйн нэгжүүдийн эзлэх хувь дунджаар 90 орчим хувь байна. Бид жил бүр ойролцоогоор 600-700 дотоодын аж ахуйн нэгжээс ажил үйлчилгээ, бараа материал худалдан авдаг бөгөөд Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимаас жил бүр шалгаруулдаг Топ-100 аж ахуйн нэгжийн жагсаалтын 30 гаруйд нь манай ханган нийлүүлэгчид багтжээ. Худалдан авалтаас гадна ханган нийлүүлэгчдийг чадавхжуулах “Чанар, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны хөтөлбөр” болон төлбөр төлөлтийн шат дамжлагыг илүү боловсронгуй болгосон зэрэг нь жижиг дунд бизнес эрхлэгчдийг бэхжүүлэхээс гадна, ханган нийлүүлэлтийн сүлжээ даяар ажлын байр шинээр бий болгож, шинэ технологи нутагшуулахад нөлөөлдөг.





Оюу толгойн 2025 оны дотоодын тэтгэлэгт хамрагдагсад

## БОЛОВСРОЛ, ЗАЛУУСЫН ХӨГЖИЛД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ НЬ

Орон нутгийн хамтын ажиллагааны салшгүй хэсэг бол боловсрол, залуусын хөгжил юм. Бид 2025 онд 117 тэтгэлэг гардуулсны зэрэгцээ өмнө нь зөвхөн Өмнөговь аймагт хэрэгжүүлдэг байсан “Залуусын хөгжлийн хөтөлбөр”-ийн цар хүрээг тэллээ.

2010 оноос хойш Оюу толгой компани боловсрол, боловсон хүчний чадавх сайжруулахад нийт 30 гаруй сая ам.долларын хөрөнгө оруулж мянга мянган залуус, мэргэжилтнүүд үр шимийг нь хүртэв.

Компанийн зүгээс хэрэгжүүлдэг “Гэрэлт” төсөл нийслэлийн гэр хорооллын 25 ерөнхий боловсролын сургуульд сэтгэл зүйн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг түгээсэн нь эдүгээ 56 мянган сурагч, багш сурган хүмүүжүүлэгч болон эцэг эхэд хүрчээ. Зургаа дахь жилдээ хэрэгжиж буй энэхүү төслийн хүрээнд 50 тусгайлан тохижуулсан кабинет байгуулагдсан. Тодруулбал, дээрх сургуулиудад нийт 25 сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөө, 25 нөхөн үржихүйн мэдээлэл авах танхим байгуулснаар өсвөр үеийнхэнд аюулгүй бөгөөд тулгарсан асуудлаа чөлөөтэй илэрхийлж болохуйц орчинг бий болгосноор өөртөө итгэх итгэл сэргэж, тулгамдсан асуудлыг даван гарах чадвар нэмэгдэхийн зэрэгцээ эрүүл мэндийн шаардлагатай мэдлэг, мэдээлэл авч буй.


Түүнчлэн, мэргэжлийн сэтгэл зүйчтэй хийх зөвлөгөө уулзалт, үе тэнгийнхэн хоорондоо зөвлөлдөх нөхцөл боломжийг бүрдүүлсэн нь өсвөр үеийнхэнд сэтгэл санааны, нийгмийн болон сэтгэл зүйн тулгамдсан асуудлаа шийдвэрлэх, давж гарахад нь дэм болж байна. Төслийн хүрээнд санал болгож буй эдгээр үйлчилгээ нь тулгамдсан асуудлуудад нь зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ амиа хорлох оролдлого, үе тэнгийн дээрэлхэлт, бэлгийн дарамт болон бусад төрлийн хүчирхийлэл зэрэг ноцтой боловч тэр бүр мэдэгддэггүй асуудлыг ил болгож шаардлагатай арга хэмжээ авахад түлхэц үзүүлж буй юм. Төслийн хүрээнд “Монголын Жью Жицүгийн холбоо”-той хамтран ажиллаж сэтгэл зүйн аливаа асуудлыг спортоор даван туулахыг мөн дэмжиж байна. Одоогоор тус спортоор 180 хүүхэд идэвхтэй хичээллэж олон улсын болон улсын чанартай тэмцээнээс 44 медаль хүртсэн бахдам амжилт гаргажээ.

## ҮҮРЭГ АМЛАЛТАА ЁС ЗҮЙТЭЙ, ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙГААР БИЕЛҮҮЛЭХ НЬ

Ханбогд сумын төвийг аюулгүй, эрч хүчээр дүүрэн, хөгжиж дэвшиж буй суурин болоход дэмжлэг үзүүлэх бидний алсын хараа, хэтийн зорилго “Ханбогдын хөгжлийн хурдасгуур Оюу толгойн сан”-гаар дамжин дорвитой урагшиллаа. Тус сан нь өдрөөс өдөрт өргөжин тэлж буй Ханбогд сумын төвийн тогтвортой хөгжлийн нэгэн хөдөлгөгч хүч юм. Зөвхөн дэд бүтцээр жижиг сууринг хот болгон хөгжүүлэх боломжгүй бөгөөд эдгээр хөрөнгө оруулалт нь иргэд аж ахуйн нэгжүүдийг Ханбогдод суурьшихад илүү таатай болгох суурийг тавьж буй юм.

Ханбогдын өөрчлөн байгуулалт зам харгуй, ус түгээх, зайлуулах шугам сүлжээ болон цэцэрлэгт хүрээлэнгийн шинэчлэх бүтээн байгуулалт зэргээр олон төрлөөр илэрч байна. Өнгөрсөн онд хэрэгжиж эхэлсэн зарим төслөөс дурдвал:

- **Боловсролын хаб** нь үе тэнгийнхэн бие биеэсээ суралцах нөхцөл бололцоог нэмэгдүүлэх, өсвөр үеийнхэнд техник, технологийн дэвшлийг таниулах, хичээл сурлагадаа илүү амжилт гаргахад нь дэм болох зорилготой байгуулагдсан.
- **Орон байр хөгжлийн хөтөлбөр** нь хүрээнд эрчим хүчний хэмнэлттэй жишиг сууцыг сурталчлан таниулах, нутгийн иргэдийн хашааны зохион байгуулалтыг сайжруулах жишиг загвар санал болгох зорилготой.
- **Ханбогдын малын гаралтай бүтээгдэхүүнийг дэмжих төсөл** нь орон нутгийн засаг захиргаа болон малчдын хоршооллын дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй гурван жилийн хугацаанд үргэлжлэх энэхүү төсөл нь ингэний хоормог, органик бордоо зэрэг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн бий болгох, малын ашиг тусыг нэмэгдүүлэх зорилготой юм. Энэ хүрээнд Оюу толгой компани нийт 490 мянган ам.долларын хөрөнгө оруулж иргэдийн амьжиргаа, орон нутгийн эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх үхрийн тэжээлийн ферм байгуулахаар ажиллаж байна.
- **Монгол Улсын Засгийн газартай хөгжүүлж буй түншлэл** 2025 оны 8 дугаар сард Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулснаар шат ахив. Санамж бичиг нь Ханбогдыг эдийн засгийн зангилаа суурин болгоход төвлөрч буй бөгөөд энэ хүрээнд нэмүү өртөг илүү шингэсэн бүтээгдэхүүн бий болгох, говийн бүсийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор усны нөөцийн судалгаа хийх зэрэг ажил багтсан.
- **12.5 км урт хатуу хучилттай автозам** ашиглалтад орсноор Ханбогд сумын төв Тавантолгойн нүүрс тээврийн замтай хатуу хучилттай автозамаар холбогдлоо. Уг бүтээн байгуулалт нь орон нутгийн эдийн засгийн хөгжилд түлхэц үзүүлээд зогсохгүй Оюу толгой үйлдвэр зүг чиглэсэн тээвэр логистикт эерэг нөлөө үзүүлэх гэх зэргээр Ханбогдын хөгжилд хувь нэмэр оруулах ач холбогдолтой юм. Орон нутгийн иргэдтэй зөвшилцсөний үндсэн дээр хэрэгжүүлсэн энэхүү автозамын аюулгүй байдлыг хангах зорилгоор 220 метр төмөр бетон далан болон 27 ус зайлуулах шуудуу хийгджээ.





Хархорум хотын хөгжлийн төслийн нээлтийн ёслол.  
Оюу толгой компани 100,000 мод тарихаар амлав.

## ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН – ХӨГЖИЛ ДЭВШИЛД ХӨТӨЛСӨН АРВАН ЖИЛ

Урт хугацаанд үргэлжлэх, олон талт оролцоог хангасан хөгжлийг дэмжих Оюу толгой компанийн хүчин чармайлт аймгийн түвшинд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гаар дамжин илэрдэг. “Оюу толгой” компанийн жил бүрийн 5 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар дамжуулан тус сан байгуулагдсан цагаасаа өнөөг хүртэл нийт 50 гаруй сая ам.долларыг бүс нутгийн тогтвортой хөгжил болон иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд зарцуулжээ.

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь 2015 онд байгуулагдсанаас өнөөг хүртэл 583 төсөл хэрэгжүүлж үүнээс давхардсан тоогоор 860 мянга гаруй хүн үр шимийг нь хүртсэн байна. Тус сангийн төсөл хөтөлбөр нь боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц, байгаль орчин болон бизнес эрхлэлтийг дэмжих зэрэг өргөн цар хүрээг хамран хэрэгждэг. Бүрэн тоноглогдсон цэцэрлэг, сургуулийн барилгаас эхлээд өв соёлоо түгээн дэлгэрүүлэх барилга байгууламж, эмнэлэг хүртэл “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн үйл ажиллагаа Өмнөговь аймагт ул мөрөө тод үлдээжээ.

Арван жилийн өмнөхтэй харьцуулбал Өмнөговь аймаг руу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөн нэмэгдэж тэр хэрээр нэн хэрэгцээт дэд бүтэц, үйлчилгээг бий болгох шаардлага өсөж байна. Орон нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулах, иргэдэд шинэ боломж нээх дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа нь тус сангийн нүдэнд хамгийн ил харагдах ололт билээ. Онцолбол зохих бүтээн байгуулалтын зарим ажлыг дурдвал Даланзадгад хотод баригдсан хэд хэдэн сургууль, цэцэрлэгүүд, Говийн байгаль, түүхийн музей, ус болон дулааны хангамжийн шугам сүлжээ, ус цэвэршүүлэх байгууламж болон хөдөө орон нутгийн иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг илүү хүртээмжтэй болгох, орон нутгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чадавхыг сайжруулах зорилгоор Баян-Овоо, Мандал-Овоо болон Цогт-Овоо сумдад байгуулсан эрүүл мэндийн төвийн барилга зэргийн дурдаж болно.

Хэрэгжүүлсэн төсөл,  
хөтөлбөрийн тоо

**583**

Төсөл, хөтөлбөрөөс үр шим  
хүртсэн иргэд (давхардсан  
тоогоор)

**860 мянга**

Шинээр бий болсон  
ажлын байр

**750**

131 аж ахуйн  
нэгжид нийт

**1.9 сая**

ам.долларын бичил  
зээл олгов.

## ХЭРЭГЖҮҮЛСЭН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨСЛҮҮД (2025 ОНЫ IV УЛИРЛЫН БАЙДЛААР)



Боловсрол	58.5 мянган ам.доллар
Байгаль орчин	8.5 мянган ам.доллар
Өв соёл, түүх	18.6 мянган ам.доллар
Эрүүл мэнд, сайн сайхан байдал	8.5 мянган ам.доллар
Орон нутгийн дэд бүтэц	3 сая ам.доллар
Орон нутгийн бизнес эрхлэлтийг дэмжих	600.7 мянган ам.доллар
Спортын цогцолбор	3.1 сая ам.доллар

Орон нутагт зөвхөн дэд бүтцийг хөгжүүлэхээс гадна хүний хөгжилд чиглэсэн үйл ажиллагааг Оюу толгой үйлдвэр дэмждэг. “Говийн оюу тэтгэлэгт хөтөлбөр” нь эрүүл мэнд, боловсрол, инженерчлэл, мэдээллийн технологи зэрэг чухал ач холбогдолтой чиглэлд боловсон хүчин бэлтгэхэд чиглэсэн үндсэн хөтөлбөр юм. 2016 оноос хойш нийт 762 оюутан сургалтын төлбөрийн бүрэн тэтгэлэг хүртсэний 85 хувь нь Өмнөговь аймагтаа хөдөлмөр эрхлэн бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулж байна.

“Бизнесийн боловсрол олгох хөтөлбөр” нь орон нутгийн бизнес эрхлэлтийг идэвхжүүлж 131 аж ахуйн нэгжийг бичил зээл авах боломжоор ханган, улмаар нийт 1.9 сая ам.долларын зээл олгожээ. Ингэснээр Өмнөговь аймагт 164 шинэ бөгөөд байнгын ажлын байр бий болжээ. Харин “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн үйл ажиллагааны цар хүрээнд нийт 750 ажлын байр аймгийн хэмжээнд шинээр үүссэн байна.

Тус сангийн зүгээс эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлсэн санаачилгууд нь эмнэлгийн барилга байгууламжид засвар хийх, шинэ тоног төхөөрөмжөөр тоноглох, эмнэлгийн ажилчдыг сургалтад хамруулах замаар боловсон хүчний чадавхыг сайжруулах зэргээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулсан. Боловсролын тусгайлсан хөтөлбөрүүд нь багшлах ур чадварыг нэмэгдүүлэх, суралцах орчин нөхцөлийг сайжруулах замаар залуусын ур чадварыг нэмэгдүүлэхэд урт хугацаандаа дэмжлэг үзүүлэх зорилготой юм.



Оюу толгой үйлдвэрийн хөрөнгө оруулалттай Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн санхүүжилтээр Өмнөговь аймгийн Даланзадгад суманд баригдсан 33 дугаар цэцэрлэг

### **Өмнөговь аймагт хэрэгжсэн, томоохон төслөөс онцолбол:**

#### **Даланзадгад дахь цэцэрлэг, сургуулийн цогцолбор**

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн санхүүжилтээр 1,200 хүүхдийн багтаамжтай сургууль, 200 хүүхдийн багтаамжтай цэцэрлэг 2025 онд Даланзадгад хотноо ашиглалтад орсон. Нийт 7 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн энэхүү төсөл нь Даланзадгадын захын бүсэд боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд 140 ажлын байр шинээр бий болгосон юм.

#### **Говийн байгаль, түүхийн музей**

Өв соёлыг түгээн дэлгэрүүлэх дөрвөн давхар энэхүү музей нь олон улсын стандартын дагуу “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 3 сая ам.долларын санхүүжилтээр баригдсан. Музей нь өдгөө бүс нутгийн балар эртнээс өнөөг хүртэлх баялаг түүх, говийн нүүдэлчдийн гайхалтай өв соёлыг хадгалах, түгээн дэлгэрүүлэх хүндтэй бөгөөд хариуцлагатай ажлыг гүйцэтгэж буй бөгөөд говийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна.

#### **Цэцэрлэгийн таван шинэ барилга**

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 6.6 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар зорилтот сумдад бүрэн тоноглогдсон таван цэцэрлэгийн барилгыг барьж хүлээлгэн өгснөөр алслагдмал сумдын олон зуун хүүхэд аюулгүй бөгөөд орчин үеийн орчинд сурах нөхцөл бий болов.

### **Ханбогдын сумын төвийн ус, халаалтын систем**

Иргэдийн амьдрах орчныг сайжруулах, ус дулааны нэн шаардлагатай дэд бүтцээр хангах зорилгоор “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” цэвэр усны шугам, халаалтын систем бий болгох төсөл хэрэгжүүлж 2.5 сая ам.доллараар санхүүжүүлэв.

### **Даланзадгад дахь ус цэвэршүүлэх байгууламж**

Байгаль орчны тогтвортой байдлыг дэмжих ажлын хүрээнд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь Даланзадгадад шинээр ус цэвэршүүлэх байгууламж байгуулах төслийг санхүүжүүлэв. Төсөл нь усыг илүү үр ашигтай ашиглах, улмаар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах юм.

### **Эрүүл мэндийн төвийн барилга**

Баян-Овоо, Мандал-Овоо болон Цогт-Овоо сумдад эрүүл мэндийн төв барих ажилд тус сангийн зүгээс нийт 1.8 сая ам.доллар төсөвлөжээ. Барилгууд ашиглалтад орсноор эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж орон нутагт сайжрахын зэрэгцээ орон нутаг дахь эрүүл мэндийн тогтолцоог сайжруулахад дэмжлэг болно.

## **ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ НЬ**

Оролцогч талуудтай үр дүнтэй яриа өрнүүлж санал, гомдол бүрийг хариуцлагатай хянан үзэж, шийдвэрлэхийг бид чухалчилдаг. 2025 оны байдлаар Орон нутаг, нийгмийн хариуцлагын баг нийт 497 удаагийн уулзалтаар 1,089 малчин, орон нутгийн иргэн болон оролцогч талуудын төлөөллийн санал, гомдлыг хүлээн авсан байна. Эдгээр нь уулзалт, хэлэлцүүлэг болон Гурван талт зөвлөл зэрэг албан ёсны хэлбэрээр авч хэрэгжүүлсэн ажил юм. Өнгөрсөн онд энэ шугамаар нийт 7 гомдол хүлээн авсан байна. Харин орон нутгийн засаг захиргаа, орон нутгийн иргэд, төрийн бус байгууллага болон Оюу толгой үйлдвэрийн төлөөллөөс бүрдэх Гурван талт зөвлөлийн иргэд оролцогч талуудаас гомдол ирүүлээгүй болно.







# ЭХ ДЭЛХИЙГЭЭ ЭРХЭМЛЭН ХАМГААЛНА





## ХӨРСТ ДЭЛХИЙ

---

Ус дахин  
ашиглалт

**86.5%**

Нэг тонн хүдэр  
боловсруулахад  
ашигласан ус

**0.4 m<sup>3</sup>**

---

Ус ашигласны төлбөр (2013-2025)

**79.4 сая ам.доллар**

---

Цахилгаан  
өөрөө  
буулгагч

**30**

Гүний уурхайн  
зай хураагуураар  
ажилладаг цахилгаан  
тээврийн хэрэгсэл

**24**

---

Нөхөн  
сэргээсэн нийт  
талбай

**1,210 га**

Дүйцүүлэн  
тарьсан мод

**3.3 сая**

---

Нийт тарьсан мод

**35 сая**

---

Байгаль орчны  
ноцтой осол

**0 (зорилт: 0)**



### Зай хураагуур солих байгууламж

Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг хамгийн бага түвшинд хадгалах нь Оюу толгой үйлдвэрийн үйл ажиллагааны стратегийн үндсэн чиглэлийн нэг бөгөөд хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагаа эрхлэхийн зэрэгцээ байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээгээр манлайлах зорилго тавин ажиллаж байна. Бид хүлэмжийн хийн ялгарлаа бууруулах, хүрээлэн буй орчноо нөхөн сэргээх, ордын ашиглалтын үр ашгийг үйл ажиллагааны шат дамжлага бүрд сайжруулах чиглэлд тууштай ахиц гаргасаар байна.

Энэ жил бид хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоо урагшлуулж, уул уурхайг ирээдүйд сэргээгдэх эрчим хүчээр хангахад чиглэсэн чухал алхам болох зай хураагуурт цахилгаан өөрөө буулгагчийг үйл ажиллагаандаа туршилтаар нэвтрүүлэв.

Дэлхийн бусад уурхайтай харьцуулахад Оюу толгой үйлдвэрийн усыг ариглан гамнах үзүүлэлтээр тэргүүлэгчдийн нэг хэвээр байна.

Бид “100 сая мод” хөтөлбөрөөр дамжуулан Монгол Улсын “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд дорвитой хувь нэмэр оруулж байгаа болно.

Эдгээр хүчин чармайлт нь биологийн олон янз байдлыг хамгаалах санал санаачилгууд, хог хаягдлын дахин боловсруулалтын төсөл хөтөлбөрүүдтэй хамт Өмнөговь аймгийн байгаль орчны урт хугацааны тэнцвэрийг дэмжихийн зэрэгцээ Оюу толгой үйлдвэрийн үйл ажиллагааны урт хугацааны тогтвортой байдлыг хангах манай хэтийн хугацааны зорилго юм.



Зай хураагуураар ажилладаг цахилгаан ачааны авто машин

## ХҮЛЭМЖИЙН ХИЙГ ТЭГЛЭЖ, ИННОВАЦЫГ ӨДӨӨХ НЬ

Уур амьсгалын өөрчлөлт зэрэг хүн төрөлхтний өмнө тулгамдсан нийтлэг сорилтын улмаас даамжирч буй өөрчлөлттэй дэлхий дахин нүүр тулж байна. Эдгээр сорилтыг даван туулах арга зам биднээс ажлын шинэ арга барил, сэтгэлгээгээ өөрчлөхийг шаардах боллоо. Оюу толгой үйлдвэр байгаль орчинд үзүүлэх нөлөөгөө бууруулж, улмаар хүлэмжийн хийн ялгарлыг тэглэх дэлхий дахины зорилгод бодит хувь нэмэр оруулах үүрэг хариуцлагаа ухамсарлаж энэ чиглэлд тодорхой ажил, арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Эдүгээ Оюу толгой үйлдвэрийн ялгаруулж буй хүлэмжийн хийн 71 хувь нь цахилгаан эрчим хүчний хэрэглээнээс, 20 хувь нь дизель түлшнээс, 8 хувь нь Дулааны төв станцаас, үлдсэн 1 хувь нь бусад эх үүсвэрүүдээс ялгарч байна. 2050 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг тэглэх компанийн зорилтын хүрээнд бид 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлын түвшинг 30 хувь болгон бууруулах дунд хугацааны зорилт тавьж, түүндээ хүрэх тодорхой, хэрэгжихүйц төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Энэ зорилтын хамгийн чухал хэсэг нь инновац, технологийн шинэчлэл юм. Дэлхий даяар уул уурхайд ашиглагддаг хүнд техникүүд цахилгаан үүсвэр рүү шилжиж байна. Оюу толгой үйлдвэр ч дэлхийтэй хөл нийлүүлж энэ өөрчлөлтийг түүчээлж буй. Тодруулбал, Рио Тинто болон БНХАУ-ын Төрийн эрчим хүчний хөрөнгө оруулалтын корпорацитай хамтран зай хураагуур солих технологитой цахилгаан өөрөө буулгагчийг хоёр жилийн хугацаанд турших төслийг амжилттай эхлүүлээ. Энэ санаачилга нь дизель түлшнээс хараат байдлыг бууруулах, үйл ажиллагааны арга барилаа шинэчлэх, аюулгүй, цэвэр, тогтвортой уул уурхайн ирээдүй рүү урагшлах ахиц дэвшлийг түргэтгэх чухал алхам мөн.

Төсөлд 91 тонны даацтай 8 ширхэг цахилгаан өөрөө буулгагч, их багтаамжийн 13 ширхэг зай хураагуур, мөн зай хураагуур солих автомат станц багтсан. Зай хураагуур цэнэглэгдэхийг хүлээлгүй эдгээр машинууд зай хураагуураа 7 минутын дотор сольж, утаагүй, чимээ шуугиан болон доргилт багатай, тасралтгүй ажиллагаагаа хангаж байгаа нь уг төслийн онцлог юм.

Жилийн эцсийн байдлаар Оюу толгой үйлдвэрт нийт 30 ширхэг цахилгаан тээврийн хэрэгсэл байгаагаас 24 нь гүний уурхайд идэвхтэй ашиглагдаж байна. Одоогийн байдлаар туршилт, тохиргоо хийгдэж буй гурав, хүргэгдэж буй найман цахилгаан тээврийн хэрэгсэл байгаа бөгөөд ирэх жилүүдэд хүлэмжийн хий ялгаруулдаггүй тээврийн хэрэгсэл манай тээврийн хэрэгслийн томоохон хэсгийг бүрдүүлэх юм.

Энэ шинэчлэл нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулаад зогсохгүй, дизелийн утааг бууруулж, гүний уурхайн аюулгүй байдал, ажлын нөхцөлийг ч мөн дээшлүүлнэ.



## ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ НӨХӨН СЭРГЭЭЖ, БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ НЬ

Бидний байгаль орчноо хамгаалах ажил нь уурхайн цогцолбороор хязгаарлагдахгүй. 2025 онд Сэлэнгэ аймгийн Цагаан зүрийн голын орчимд хууль бус, хариуцлагагүй уул уурхайн олон жилийн үйл ажиллагааны уршгаар ихээхэн доройтсон 600 га газрыг Оюу толгой үйлдвэр нөхөн сэргээлээ. Энэ нь 12 сая мод тарихтай дүйцэхүйц хэмжээний ажил бөгөөд голын урсцыг сайжруулж, хөрсний тогтвортой байдлыг нэмэгдүүлэн, биологийн олон янз байдлыг дэмжихэд чухал ач холбогдолтой юм. Тухайн газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авч, цаашид эко аялал жуулчлал хөгжих боломж бүрдээд байна.

Сүүлийн гурван жилийн хугацаанд бид Сэлэнгэ, Дархан-Уул аймагт нийт 1,210 гаруй га газрыг нөхөн сэргээж, 35 сая мод тарихтай дүйцэхүйц ажлыг гүйцэтгэв. Компанийн “100 сая мод” хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймгийн нутагт нэмж 3.3 сая мод тарьж, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд хувь нэмэр орууллаа.

Манай биологийн олон янз байдлыг хамгаалах хөтөлбөр нь экологийн нөлөөллийг үр дүнтэй удирдаж, сөрөг нөлөөг бууруулахын тулд нөлөөллийн шаталсан аргачлал болох “зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх, нөхөн төлбөрөөр тэнцвэржүүлэх” зарчмыг тууштай хэрэгжүүлж байна. Ургамалжилт, зэрлэг ан амьтан болон усны нөөцөд хийдэг иж бүрэн тандалт, хяналт шинжилгээ нь манай үйл ажиллагаа экосистемийн тэнцвэрийг дэмжиж, бүс нутгийн уур амьсгалын тэсвэржилтийг бэхжүүлэхэд чиглэж байгаа болно.

2025 онд бид экологи, нөхөн сэргээлтээр олон улсад тэргүүлэгч БНХАУ-ын “М Грасс групп”-тэй стратегийн түншлэл байгуулж, Ханбогд сумын Ухаа заг орчимд ойжуулалтын төсөл хэрэгжүүлэхээр хамтран ажиллаж эхэллээ. Энэ хүрээнд Оюу толгой үйлдвэр дотоодын мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд мэдлэг туршлага, арга зүйн шинэлэг шийдлийг хуваалцаж, доройтсон бэлчээр нутгийг нөхөн сэргээхэд дэмжлэг үзүүлнэ. Уг санаачилгыг Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцын Талуудын бага хурлын 17 дугаар чуулган (UNCCD COP17)-д Монголын тэргүүлэх төсөл байдлаар танилцуулахаар төлөвлөж байгаа болно.

## “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНД ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛАХ НЬ

Оюу толгой үйлдвэр нь “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг идэвхтэй дэмжин ажиллаж байна. 2025 онд бид Хархорум хотын Их хаадын цэцэрлэгт хүрээлэнд 143.9 га талбайд 100,000 мод тарих ажлыг эхлүүлж, чингэхдээ нутгийн экологийн нөхцөлд тохирох шилмүүст болон навчит мод түлхүү сонгов. Улсын хэмжээнд ойн үрслэгээний аж ахуйн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор шаардлагатай 80 төрлийн тоног төхөөрөмж худалдан авахад 429,000 ам.долларын санхүүжилт олгов.

Ханбогд суманд байрлах 5 га талбай, 15 хүлэмжтэй Оюу толгой үйлдвэрийн Байгалийн ургамлын үржүүлгийн газар нь 43 зүйлийн ургамал үржүүлж, газрын нөхөн сэргээлт болон олон нийтийн ногоон байгууламжийн санаачилгуудын хэрэгцээнд жил бүр 100,000 хүртэл суулгац бэлтгэдэг. Сүүлийн гурван жилд Өмнөговь аймгийн Ханбогд, Цогт-Овоо, Баян-Овоо, Сэврэй, Манлай сумдад нийт жилд 1.75 сая суулгац үйлдвэрлэх хүчин чадалтай үрслэгээний аж ахуйг байгуулж, бүсийн ойжуулалтын урт хугацааны дэд бүтцийг бэхжүүллээ.






Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Цагаан зүрийн гол орчимд “Оюу толгой” компанийн нөхөн сэргээсэн талбай

## УС АРИГЛАН ХАМГААЛАЛТААР ЖИШИГ УУРХАЙ БОЛОХ НЬ

Ус чандмань эрдэнэ билээ. Усыг Оюу толгой үйлдвэр ариг гамтай ашиглаж, дэлхийд жишиг тогтоож буй уурхай юм. 2025 онд бид 1 тонн хүдэр боловсруулахад 0.407 шоо метр ус хэрэглэсэн нь ижил төрлийн уурхайн дэлхийн дунджаас бараг гурав дахин бага үзүүлэлт юм. Бид ашигласан усныхаа 86.5 хувийг дахин ашиглаж салбартаа тэргүүлэгчдийн эгнээнд багтаж байгаа нь усны менежментийн дэвшилтэт систем, тогтмол хяналт шинжилгээний үр дүн.


“Гүнээсээ хайрлая” аяны хүрээнд бид усыг ариглахын ач холбогдлын талаар олон нийтийг тасралтгүй мэдээллээр хангаж, “Цэнхэр алт” үндэсний хэлэлцүүлэг зэрэг санаачилгаар дамжуулан усны хариуцлагатай менежментэд хувь нэмэр оруулж буй иргэд, байгууллагуудыг урамшуулж байна.



Дэлхийн дундаж



Оюу толгойн  
дундаж



# 86.5%

2025 онд ус дахин ашиглалт 86.5 хувьд хүрч зорилтот түвшин болох 80 хувийг давав.




## ХОГ ХАЯГДЛЫН ХАРИУЦЛАГАТАЙ МЕНЕЖМЕНТ

Бид эрдсийн бус хог хаягдлыг хогийн цэг рүү илгээх хувь хэмжээг 2025 онд 25–30 хувь болгон бууруулах зорилгоо хамтрагч байгууллагуудаа нэмэгдүүлэх, нийтлэг хог хаягдлын менежмент, ангилан ялгалтыг сайжруулах замаар тууштай хэрэгжүүлсээр байна. 2025 онд эрдсийн бус хог хаягдлыг хогийн цэг рүү илгээсэн жилийн дундаж 20.3 хувь байв. Үүссэн эрдсийн бус хог хаягдлын 74 хувь нь дахин боловсруулах боломжтойд ангилагдсан бол 68 хувийг бодитоор дахин боловсруулсан бөгөөд энэ нь үндэсний дахин боловсруулах компаниудтай байгуулсан хамтын ажиллагааны үр дүн юм. Эдгээр үйл ажиллагаа нь байгаль орчны ноцтой осолгүй ажиллах, үйл ажиллагаанаас үүдэх байгаль орчны нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах бидний зорилгыг илэрхийлж байна.

## ДАХИН БОЛОВСРУУЛАХ ХАЯГДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

(ХУВЬ, САРААР, 2025)



Оюу толгойн хаягдал өтгөрүүлэгч байгууламж





# ТОГТВОРТОЙ ҮНЭ ЦЭНЭ БҮТЭЭНЭ





## ХҮРТЭХ ӨГӨӨЖ

---

Борлуулалтын орлого

**4.99** тэрбум ам.доллар

---

Татвар, хураамж бусад төлбөр

**660** сая ам.доллар

---

Татвар, хураамж бусад  
төлбөр (2010-2025)

**5.5** тэрбум ам.доллар

---

Урсгал капитал зардал

**165** сая ам.доллар

---

Гүний уурхайн урсгал  
капитал зардал

**769** сая ам.доллар

---

Гүний уурхайн капитал  
зардал

**422** сая ам.доллар

Санхүүгийн ашигтай ажиллагаа нь хувь нийлүүлэгчдийн болон олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг, өгсөн амлалтдаа хүрэх, урт хугацааны өсөлт хөгжлийн суурийг тавих ач холбогдолтой нэн чухал үзүүлэлт юм. 2025 оны хувьд Оюу толгой үйлдвэр үйл ажиллагаа болон санхүүгийн гүйцэтгэлийн үзүүлэлтээ шат ахиулсан амжилттай үдэв. Баяжуулах үйлдвэрийн тохируулгын төсөл болон Гүний уурхайгаас газрын гадарга руу хүдэр тээвэрлэх туузан дамжуургыг амжилттай ашиглалтад оруулсан нь үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чухал алхам боллоо.


Цаашилбал, үйл ажиллагааны гүйцэтгэл нэмэгдсэн, олон улсын зах зээл дээрх металлын үнэ өссөн зэрэг нь түүхэн дээд хэмжээний орлого олоход түлхэц үзүүлэв. Бид түүхэндээ анх удаа эерэг чөлөөт мөнгөн урсгал бүртгэж, уурхайг барьж байгуулан хөгжүүлэхэд хийсэн урт хугацааны хөрөнгө оруулалтын өгөөжийг бататган харууллаа.

## ЗАХ ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ БА ҮНЭ

Дэлхийн түүхий эдийн зах зээл 2025 оны турш савлагаатай байв. Зэсийн бодит үнэ тайлант хугацаанд дунджаар фунт тутамд 4.50 ам.доллар, жилийн сүүлчээр АНУ-ын долларын ханшийн сулрал, АНУ-аас гаднах бүсүүдэд зах зээлийн хатуу төлөв (нөөцийн шилжилт, хумигдал) үүссэнээр фунт тутамд 5.67 ам.доллар хүртэл өсөв.

Алтны бодит үнэ 2025 онд дунджаар унц нь 3,600 ам.долларт хэлбэлзсэн бөгөөд макро эдийн засгийн тодорхойгүй нөхцөл, геополитикийн хурцадмал байдлын дунд Биржээр арилжаалагддаг сан (ETF)-ын урсгал хүчтэй өсөж, Төв банкнуудын худалдан авалт эрэлтийг цаашид дэмжлээ. Жилийн эцэст алт унц нь 4,368 ам.доллаароор хаагдав. Эдгээр савлагааны дунд Оюу толгой үйлдвэр үйл ажиллагааны үр ашиг ба зардлын сахилга батыг чанд сахиснаар санхүү гүйцэтгэлээ эерэг хадгалж чадлаа.

## ОЮУ ТОЛГОЙ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (сая ам.доллар)



## МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ ОЮУ ТОЛГОЙ ҮЙЛДВЭРИЙН ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР

Уул уурхай нь их хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг салбар бөгөөд хөрөнгө оруулалтын хэмжээ нь өгөөж хүртэх цаг хугацааг тодорхойлж байдаг. Оюу толгой үйлдвэр шиг төслүүдэд олон тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардагдахаас гадна тоног төхөөрөмжийг хэвийн ажиллагааг хангах, шинэ олборлолтын бүсүүдийг хөгжүүлэхэд нэмэлт хөрөнгө шаардагддаг. Ашигтай ажиллахаас өмнө ч эдгээр зардал нь улсын төсөв, ажилчдын цалин, ханган нийлүүлэгчид, орон нутагт олон талын үр өгөөж бий болгодог.

Уурхайн үнэ цэнэ цаг хугацааны явцад бий болсон эдийн засгийн идэвхжилээс харагдана. Бүтээн байгуулалтын үе шат онцгой нөлөө үзүүлнэ. Үндэсний компаниудтай хийсэн худалдан авалт, бусад хамтын ажиллагаа, төсөвт төлж буй татвар, хураамж, үндсэн ажилчдын цалинд 2010 оноос хойш 21.3 тэрбум ам.доллар зарцууллаа. Энэ нь олон мянган ажлын байр, ханган нийлүүлэгчдэд томоохон боломжийг бий болгоод зогсохгүй олон нийтэд үлдэх дэд бүтэц, хүний нөөцийн ур чадвар, гадаадын хөрөнгө оруулалтын урсгалыг бүрдүүлж, Монголын олон улсын бизнес дэх нэр хүндийг бэхжүүлэв.

Гүний уурхайн үйлдвэрлэл цаашид нэмэгдэхийн хэрээр тогтвортой үйл ажиллагаанаас үнэ цэнэ бий болно.



## ТОГТМОЛ САЙЖРУУЛАЛТ БА ҮНЭ ЦЭНИЙН БҮТЭЭМЖ

2025 онд компани Тогтмол сайжруулалтад анхааран Нөөц боломжоо бүрэн дайчлах хөтөлбөрийг идэвхтэй хэрэгжүүлж ирлээ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд байгууллага даяар зардал хэмнэх болон үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх санал санаачилгыг ажилчид өөрсдөө тодорхойлж хэрэгжүүлсэн.

Үүний үр дүнд 2025 онд зэсийн нийлүүлэлт болон алт үйлдвэрлэл төлөвлөлтөөс давсан бөгөөд энэ нь хэлтэс хооронд хэрэгжүүлсэн арван нэр төрлийн санаачилга болон бизнесийн нэгжүүдийн хамтын ажиллагааны үр дүн юм.



## САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Оюу толгой үйлдвэрийн борлуулалтын орлого 4.99 тэрбум ам.долларт, үндсэн үйл ажиллагааны, татвар, хүү, элэгдлийн өмнөх ашиг 3.47 тэрбум ам.долларт хүрсэн нь зэс, алтны үйлдвэрлэлийн өсөлт, тогтвортой боловсруулалт, үйл ажиллагааны үр ашгийн тасралтгүй сайжруулалтын үр дүн юм.

Зардлын сахилга батыг жилийн турш чанд баримталсан бөгөөд урсгал капиталын зардал 934 сая ам.доллар, гүний уурхайн капитал зардал 422 сая ам.доллар байсан нь уурхайн урт хугацааны хөгжлийн стратеги болон гүний уурхайн олборлолт нэмэгдүүлэх зорилттой нийцэв.

2025 оны үр дүн бол өмнөх жилийн санхүүгийн эерэг өсөлтөд тулгуурласан үзүүлэлт юм. 2024 онтой харьцуулбал борлуулалтын орлого 129 хувиар (2.81 тэрбум ам.доллар) өсөж 4.99 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд үндсэн үйл ажиллагааны, татвар, хүү, элэгдлийн өмнөх ашиг 388 хувиар (2.76 тэрбум ам.доллар) өсөж 3.47 тэрбум ам.доллар байв. Чөлөөт мөнгөн урсгал мэдэгдэхүйц сайжирч оны эцсийн байдлаар 1,914 сая ам.доллар болов. Эдгээр ололт амжилт нь нь бизнесийн бүх чиглэлд үйл ажиллагааны өндөр гүйцэтгэлийг илэрхийлж байна.

## САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД (сая ам.доллар)

Мөнгөн урсгалын тойм (сая ам.доллар)	2021	2022	2023	2024	2025
Нийт мөнгөн урсгал	939	411	511	1,085	3,281
Нийт капитал худалдан авалт	(1,003)	(1,088)	(1,254)	(1,325)	(1,367)
Чөлөөт мөнгөн урсгал	(65)	(676)	(743)	(239)	1,914
Цэвэр орлого	2,041	1,424	1,625	2,184	4,992
Хүү, татвар, элэгдэл, хорогдлоос өмнөх ашиг	1,259	435	575	710	3,467
<b>Санхүүжилтийн үйл ажиллагаа</b>					
Авсан санхүүжилт	404	1,542	1,061	871	-
Хүүгийн төлбөр	(160)	(210)	(366)	(491)	(567)
Зээлийн эргэн төлөлт	(43)	(403)	-	-	(476)



## САНХҮҮЖИЛТИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ 2025 (сая ам.доллар)

Эх үүсвэр	Зээл	Зээлийн төрөл	Үндсэн төлбөр			Хүү			Нийт Зээлийн Үлдэгдэл
			Үндсэн төлбөр	Эргэн төлөлт	Нийт	Хуримтлагдсан ХҮҮ	Эргэн төлөлт	Нийт	
Гуравдагч этгээд	Төслийн санхүүжилт	Давуу эрхтэй зээл	3,879	(100)	3,779	331	(318)	13	3,792
	Эргэлтийн хөрөнгийн зээл		70	-	70	5	(5)	-	70
Хувьцаа эзэмшигч	Хувьцаа эзэмшигчдийн зээл	Хоёрдогч өр	6,088	-	6,088	6,453	-	6,453	12,541
	Урьдчилгаа төлбөрийн гэрээ		1,600	(334)	1,266	451	(94)	358	1,624
	Спонсорын давуу эрхтэй зээл	Давуу эрхтэй зээл	1,651	(43)	1,608	152	(146)	6	1,614
<b>Нийт</b>			<b>13,288</b>	<b>(476)</b>	<b>12,811</b>	<b>7,392</b>	<b>(562)</b>	<b>6,829</b>	<b>19,641</b>
Элэгдэл, хорогдлын зардал									(58)
Санхүүгийн тайлангийн өртөг бодсон үлдэгдэл									19,583



## ОЮУ ТОЛГОЙ ҮЙЛДВЭРИЙН ӨГӨӨЖ ХЭРХЭН ХҮРДЭГ ВЭ?

Оюу толгой үйлдвэрийн өгөөж нь өргөн цар хүрээг хамарч он удаан жил үргэлжилнэ. Татвар, хураамж болон бусад төлбөр зэрэг төсөвт төвлөрүүлэх шууд орлогоос гадна макро эдийн засгийн идэвхжил, тогтвортой ажлын байр, ур чадвартай ажиллах хүчнийг бий болгох, бүс нутгийн эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжил, Монголын бизнес эрхлэгчид болон ханган нийлүүлэгчдийн боломжийг тэлэх замаар нэмүү үнэ цэнийг ч давхар бий болгодог. Ирээдүйд хуваарилагдах ногдол ашиг нь энэхүү үнэ цэнийг улам өсгөнө.

Уурхайн үйл ажиллагааны нийт хугацаанд тооцоологдсон санхүүгийн загварын дагуу хөрөнгө оруулалт түүнтэй холбоотой эрсдэлийг үүрэлгүйгээр төслийн эдийн засгийн үр өгөөжийн 60-аас доошгүй хувийг\* Монгол Улс хүртэхээр байна. Үүнд шууд бус үр өгөөж багтаагүй болно.

### МӨНГӨН ҮР ӨГӨӨЖ

#### Монгол Улсын Засгийн газар

- » АМНАТ
- » Импортын татвар, НӨАТ
- » Татварын суутгал
- » ААНОАТ
- » Бусад татвар, хураамжууд
- » Ногдол ашгийн 34 хувь

#### Хөрөнгө оруулагчид

- » Менежментийн төлбөр
- » Хувь нийлүүлэгчдийн зээлийн хүү
- » Ногдол ашгийн 66 хувь


### БУСАД ҮР ӨГӨӨЖ

- » Дотоодын худалдан авалт
- » Ажлын байр бий болох, шинэ технологи нутагших, дотоодын бизнес эрхлэлт хөгжих зэрэг эдийн засгийн эерэг дам нөлөө.
- » Олон нийтэд урт хугацаанд үр шимээ өгөх авто болон төмөр зам, цахилгаан эрчим хүч, ус зэрэг орон нутгийн дэд бүтцийн хөгжил.
- » Валют арилжааны ашиг, худалдааны тэнцэлд үзүүлэх эерэг нөлөө, ГШХО-р дамжин орж ирэх макро эдийн засгийн үр өгөөж.

- » Төслийн цар хүрээ нэмэлт хөрөнгө оруулалт хийх түшиц болно.

\* Тус графикт 2023 оны ТЭЗҮ-д тусгагдсан нөөцийн загвар болон таамаглалд үндэслэн боловсруулсан үнэ цэнийн эзлэх хувийн тооцоог харуулсан болно. Энэхүү төсөөлөл, хувь хэмжээ нь зөвхөн дээрх таамаглалын хүрээнд гарсан загварчлалын үр дүн бөгөөд суурь нөхцөл, таамаглал өөрчлөгдвөл үр дүн мөн адил өөрчлөгдөнө. Бодит төсвийн орлого болон хөрөнгө оруулагчийн өгөөж нь ирээдүйн зэсийн үнэ, үйл ажиллагааны гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын шаардлага, санхүүжилтийн бүтэц зэрэг бусад олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд энд дүрсэлсэн үзүүлэлтээс мэдэгдэхүйц өөрчлөгдөх боломжтой юм.

# ОЮУ ТОЛГОЙ ҮЙЛДВЭРЭЭС МОНГОЛ УЛС БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ХҮРТЭХ ӨГӨӨЖ



Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд хүлээлгэж өгсөн 2023 оны ТЭЗҮ-ийн төсөөлөл.

**Аргачлал:** Нөөцийг 2010 оны ам.долларын бодит дүнгээр илэрхийлсэн (хөнгөлөлтгүй мөнгөн урсгал)

## Тооцоололд орсон:

- Монгол Улсын Засгийн газар: Татвар, хураамж, бусад төлбөрүүд. Мөн ханган нийлүүлэгчдэд төлсөн НӨАТ.
- Хөрөнгө оруулагчид: Ноогдол ашиг, менежментийн төлбөр, зээлийн эргэн төлөлт (өмчийн хөрөнгө, хөрөнгө оруулсан зээл, татварыг хассан).

## Тооцоололд ороогүй:

- Монгол Улсын Засгийн газар: Дотоодын ханган нийлүүлэгчдэд төлсөн төлбөр, орон нутагт оруулсан хөрөнгө оруулалт.
- Хөрөнгө оруулагчид: Зээлийн баталгааны хураамж, Ажлын даалгавар, болон Хөрөнгө оруулалтын гэрээний өмнөх зээлүүд.

Уурхай ашиглалтад орсон эхний өдрөөс Монгол Улсын Засгийн газар Оюу толгой үйлдвэрийн үр өгөөжийг хүртэж ирсэн. Харин гадаадын хөрөнгө оруулагчдын үндсэн үр өгөөж болох 66 хувьд оногдох ногдол ашиг нь уурхайн бүтээн байгуулалтыг санхүүжүүлсэн зээлийг төлж дууссаны дараагаас хуваарилагдах юм. Одоогоор хөрөнгө оруулагчид ногдол ашиг хүртээгүй байгаа бөгөөд өөрсдийн хөрөнгө оруулалтын ашгийг хүлээсээр байна. Уурхайг босгоход авсан зээл төлөгдөж дуусмагц Монгол Улсын Засгийн газар болон гадаадын хөрөнгө оруулагчид эзэмшлийн хувьтай нь дүйцүүлэн ногдол ашгийг зэрэг хуваарилна.





## ОЮУ ТОЛГОЙ БА ИРЭЭДҮЙ


Оюу толгой үйлдвэр нь хөгжлийн дараагийн шатандаа стратегийн тодорхой чиглэлүүдтэй шилжиж байна. Урт хугацаандаа бодит үнэ цэнийг хувь нийлүүлэгчдэд бий болгох зорилтоо хадгалж, аюулгүй, ил тод, хариуцлагатайгаар төлөвлөгөөгөө хэрэгжүүлнэ. Бидний нэн тэргүүний зорилтууд нь үйл ажиллагааны гүйцэтгэлийг ахиулан хадгалах, Засгийн газар, орон нутаг, ханган нийлүүлэгчидтэй түншлэлээ улам бэхжүүлэх, мөн сайжруулалт шаардлагатай чиглэлд ахиц дэвшлийг авч ирэх.

Цаашдын өсөлт хөгжлийг техник гүйцэтгэлийн гүнзгий мэдлэг дээр суурилуулан оновчтой санхүү хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргана. “Онтрэ” ашиглалтын тусгай зөвшөөрлийн асуудлаар оролцогч талуудын байр суурь, ойлголтыг нэгтгэж ажиллахад анхаарна.



## ЗЭС ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨСӨӨЛӨЛ

(мянган тонн)



Компанийн стратегид хамт олон болон орон нутагтай өрнүүлэх хамтын ажиллагаа чухал байр суурийг эзэлсэн хэвээр байна. Тиймээс байнгын орон сууцны барилгыг барьж дуусган ажиллах нөхцөлийг сайжруулан, эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх шинэ хөтөлбөрүүдийг нэмэгдүүлнэ. Энэ хүрээнд нийт ажилчдын тэн хагасыг 2035 он гэхэд Ханбогдод оршин суух орчин нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө ажиллана. Өмнөговь болон Ханбогдод хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн сургалтыг гүнзгийрүүлж, Монгол окуутнуудын тэтгэлгийг өргөжүүлнэ.

Байгаль орчны зорилт маань тодорхой бөгөөд бодитой. Бид хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, сэргээгдэх эх үүсвэрийн ашиглалтыг нэмэгдүүлж, цахилгаан машин, тоног төхөөрөмжийг боломжтой хэмжээнд түлхүү ашиглана. Усны хэмнэлтийн тэргүүлэгч байр сууриа бататгаж, биологийн олон янз байдлын хамгаалалтыг сайжруулж, "100 сая мод" хөтөлбөрийн хүрээнд ойжуулалтыг өргөжүүлнэ. Эдгээр үйл ажиллагаа нь Монгол Улсад болон бүх хувь нийлүүлэгчдэд тогтвортой үнэ цэнэ бий болгохын зэрэгцээ 2050 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг тэглэх зорилтдоо хүрэх манай амлалтын чухал хэсэг байх болно.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

### **ШОН ХИНТОН**

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

### **АДРИАН ЙИ**

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн  
(2025 Долоодугаар сараас хойш)

### **ЭНХБААТАРЫН БАЯСГАЛАН**

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн  
(2025 Аравдугаар сар хүртэл)

### **ДЭЙРДРЭ ЛИНГЕНФЕЛДЕР**

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн  
(2025 Арванхоёрдугаар сар хүртэл)

### **КРЕЙГ СТЭГМАН**

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

### **МОРИТА СҮТЭДЖА**

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

### **СҮХБААТАРЫН МӨНХСҮХ**

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

### **ЭНХТАЙВАНЫ МЭНДТҮВШИН**

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

### **СТИВ ТИБОУ**

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн  
(2025 Зургаадугаар сар хүртэл)

### **ДОРЖДЭРЭМИЙН ЦОЛМОН**

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн  
(2025 Аравдугаар сараас хойш)

### **НАМСРАЙН ЦЭРЭНБАТ**

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

## **ТУЗ БА ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ**

### **Хувьцаа эзэмшигчдийн хурал**

Хувьцаа эзэмшигчдийн 23 дугаар хурал - 2025 оны 4-р сарын 24  
(жил тутмын ерөнхий хурал)

### **Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурал**

59 дугаар хурал – 2025 оны 1-р сарын 20-нд хуралдаж, 27-нд үргэлжилсэн

60 дугаар хурал 2025 оны 3-р сарын 13

61 дугаар хурал хурал 2025 оны 6-р сарын 5-нд хуралдаж, 8-р сарын 13-нд үргэлжилсэн

62 дугаар хурал 2025 оны 9-р сарын 4

63 дугаар хурал 2025 оны 11-р сарын 20-нд хуралдаж, 11-р сарын 25, 12-р сарын 22-нд үргэлжилсэн

### **Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурал**

Ээлжит бус 49-р хурал – 2025 оны 1-р сарын 27-нд хуралдаж, 1-р сарын 31-нд үргэлжилсэн

### **Аудит, санхүүгийн хорооны хурал**

Аудит ба Санхүүгийн Хорооны 62 дугаар хурал – 2025 оны 3 сарын 12

Аудит ба Санхүүгийн Хорооны 63 дугаар хурал – 2025 оны 6 сарын 4

Аудит ба Санхүүгийн Хорооны 64 дүгээр хурал – 2025 оны 9 сарын 3

Аудит ба Санхүүгийн Хорооны 65 дугаар хурал – 2025 оны 11 сарын 19

### **Үйл ажиллагааны хорооны хурал**

Үйл ажиллагааны Хорооны 58 дугаар хурал – 2025 оны 3 сарын 12

Үйл ажиллагааны Хорооны 59 дүгээр хурал – 2025 оны 6 сарын 4

Үйл ажиллагааны Хорооны 60 дугаар хурал – 2025 оны 9 сарын 3

Үйл ажиллагааны Хорооны 61 дүгээр хурал – 2025 оны 11 сарын 19

### **Хүний нөөц, сургалтын хорооны хурал**

Хүний нөөц ба Сургалтын Хорооны 58 дугаар хурал – 2025 оны 3 сарын 12

Хүний нөөц ба Сургалтын Хорооны 59 дүгээр хурал – 2025 оны 6 сарын 4

Хүний нөөц ба Сургалтын Хорооны 60 дугаар хурал – 2025 оны 9 сарын 3

Хүний нөөц ба Сургалтын Хорооны 61 дүгээр хурал – 2025 оны 11 сарын 19

### **Хамтын ажиллагааны хорооны хурал**

Хамтын ажиллагааны Хорооны 31 дүгээр хурал – 2025 оны 3 сарын 12

Хамтын ажиллагааны Хорооны 32 дугаар хурал – 2025 оны 6 сарын 4

Хамтын ажиллагааны Хорооны 33 дугаар хурал – 2025 оны 9 сарын 3

Хамтын ажиллагааны Хорооны 34 дүгээр хурал – 2025 оны 11 сарын 19

